

НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

2025 оны 12 дугаар сарын 15.

Улаанбаатар хот						
Д/д	Стратеги болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт
1	2	3	4	5	6	Гүйцэт гэлийн хувь
						8
Зорилго 1. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанаржуулж, эмнэлгийн тусламж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж, чанар, хүртээмжийг сайжруулан хүний хөгжлийн үзүүлэлтийг нэмэгдүүлнэ.						
Зорилт 1. Хотын төвлөрлийг сааруулж дагуул дэд төвүүдийг хөгжүүлж, “20 минутын хот” бодлогыг хэрэгжүүлнэ. /НХТЖҮЧ-9.1.1, НХЖТ-1.1.5/						
1.1	Иргэд оршин суугаа газраасаа “20 минутын зай”-д эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээ авах бүтэц, зохион байгуулалтыг хийх бэлтгэл ажлыг хангана.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	-	10	Нийслэлийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн дагуу “20 минутын хот” концепцийг хэрэгжүүлэх үүрэг бүхий НЭМГ-ын Ажлын хэсгийн гишүүдийг 2024 оны А/142 дугаар тушаалаар байгуулсан. Ажлын хэсгийн гишүүд нийслэлийн харьяа 28 байгууллага, 151 өрхийн эрүүл мэндийн төвийг 14 хотын газрын зураг дээр байрлуулж, холбогдох саналыг НЗДТГ-т хүргүүлсэн. Мөн нийслэлд үйл ажиллагаа явуулж буй хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд, эмийн сангуудыг орон зайн байршлын газрын зурагт байршуулах ажлыг зохион байгуулж байна. Нийслэлийн эрүүл мэндийн салбарыг бүсчилсэн хөгжлөөр хөгжүүлэх зураглал, бодлого, үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах шатандаа явж байна. Энэ хүрээнд “20 минутын хот” концепцийн Ажлын хэсгийн гишүүд ЭМЯ-ны Ажлын хэсэгтэй хамтарсан нийт 4 удаагийн уулзалт хурлыг зохион байгуулсан. “20 минутын хот” концепцийг хэрэгжүүлэх асуудлаар 2025 оны 08 дугаар сарын 13-ны өдөр Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамцтай уулзалт, хэлэлцүүлэг хийсэн бөгөөд уулзалт хэлэлцүүлгээр иргэд оршин суугаа газраасаа 20 минутын зайд эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээ авах бүтэц, зохион байгуулалтын талаар НЭМГ-ын ажилчид, харьяа 28 эрүүл мэндийн байгууллагын удирдлагатай өнөөгийн нөхцөл байдал, цаашдын төлөвлөгөөний талаар хэлэлцсэн.

80%

Д/д	Стратеги болон үндэслэл байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
						Улсын Их хурлаас "20 минутын хот" концепцийн хүрээнд 42 хорооллын хилийн цэсийн зааг тодорхой болоогүй, нэг жилээр хойшлуулсан тул хүлээгдлийн байдалтай байна.	
Зорилт 2. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтын хүрээнд: Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийг эрчимжүүлж, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанаржуулан, эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, нэр төрлийг нэмэгдүүлж, хүртээмжийг сайжруулна. /МУХТЖУЧ-2.2.1, МУХТЖУЧ-2.2.2, 2.2.8, МУХТЖУЧ-2.2.1, НХТЖУЧ-2.5.2.6, 2.7, 2.9.1, 2.9.2, 2.11.1, НЗДУАХ- 2.1, НХЖТ-2.1/							
2.1.	Хүүхэд, өсвөр үеийхэнд эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж, салбар хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлнэ.		Салбар дундын уулзалтын тоо	1	4	НЭМГ-ын даргын А/94 дүгээр тушаалаар "Хариуцлагатай сонголт" аяны удирдамжийг батлан, хэрэгжилтийг ханган ажиллаа. Аяны хүрээнд өсвөр насны хүүхдийн бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн асуудал, охидын жирэмслэлт, төрөлт, бэлгийн замын халдварт өвчин түүнээс урьдчилан сэргийлэх, хамтын ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр Налайх, Сүхбаатар, Баянгол дүүргийн хороодын нийгмийн ажилтан, ерөнхий боловсролын сургууль, их дээд сургуулийн эмч, нийгмийн ажилтнууд болон эх барих, эмэгтэйчүүдийн 39 хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын эмч, төлөөлөл нарын дунд 4 удаагийн уулзалт, хэлэлцүүлгийг нийт 168 хүнийг хамруулан зохион байгуулж, цаашид хамтран ажиллахаар төлөвлөсөн. Мөн Хүний папиллома вирусийн халдвар, түүний хор уршиг, умайн хүзүүний хорт хавдраас урьдчилан сэргийлэх, өвчлөлийг бууруулах, өсвөр насны хүүхдүүдийг дархлаажуулах зорилгоор Дүүргийн эрүүл мэндийн төвийн тандалтын багууд, Ерөнхий боловсролын сургуулийн эмч нар, Дүүргийн эрүүл мэндийн төвийн халдвар судлаач эмч нар, Өрхийн эрүүл мэндийн төвийн вакцинатор сувилагч нарыг хамруулан 26 удаагийн уулзалт зохион байгуулж, 3443 хүнийг хамруулсан.	100%
		12,0 НТ	Эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх нөлөөллийн уулзалтын тоо	1	6	Хүний папиллома вирусийн халдвар, түүний хор уршиг, умайн хүзүүний хорт хавдраас урьдчилан сэргийлэх, өвчлөлийг бууруулах, эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор зорилтот бүлгийн өсвөр насны хүүхдүүдийг дархлаажуулах ажлын хүрээнд 8 удаагийн	100%

Д/д	Стратеги болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
						нөлөөллийн уулзалт зохион байгуулж, 322 албан хаагч, засаг дарга нарыг хамрууллаа. Үүнд: - Баянзүрх, Баганхангай, Сонгинохайрхан, Чингэлтэй дүүргийн Засаг даргын тамгын газар тус бүрт зохион байгуулж 175 албан хаагчийг, - Сүхбаатар, Чингэлтэй, Сонгинохайрхан, Баянзүрх дүүрэгт зохион байгуулж хороодын 147 засаг дарга нарыг тус тус хамруулсан. Хүүхдэд бага наснаас нь эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл зан үйлийг төлөвшүүлж, сурагчдын нас хүйсийн онцлогт тохируулан нийт 7006 удаагийн эрүүл мэндийн боловсрол олгох сургалт зохион байгуулж, 154,773 хүүхдийг хамруулж ажиллаа. Тухайлбал: "Өсвөр үеийнхнийг сонсоё, ойлгоё" аяныг өсвөр насны хүүхдүүдэд, эцэг эх нарт, сургуулийн эмч нийгмийн ажилтан нарт, хэвлэлд мэдээлэлээр дамжуулан иргэдэд мэдээлэл сурталчилгаа хийх гэсэн 4 чиглэлээр өрнүүлэн зохион байгуулж ажилласан. Аяны хүрээнд өрх, дүүргийн эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлгүүд харьяалах нутаг дэвсгэр дэх цагдаагийн газар, Засаг даргын Тамгын газартай хамтран ерөнхий боловсролын сургуулиуд дээр "Хогт бодис, дэлгэцийн хэрэглээ, вейп ба тамхи, донтолт, эрүүл зохистой хооллолт /таргалалт, шим тэжээлийн хомсдол/, хөдөлгөөний дутагдал, нөхөн үржихүйн эрүүл мэнд, бэлгийн эрүүл ахуй, аюултай бэлгийн харилцаа, хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх нь, бэлгийн замын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх нь" сэдвүүдээр нийт 108 ерөнхий боловсролын сургуулийн 10-18 насны 41,193 сурагч, 1569 эцэг, эх асран хамгаалагчдад 972 удаагийн танхимын сургалт зохион байгуулж, зөвлөгөө өгсөн.	
		40.0НТ-	Нөхөн үржихүйн эрүүл мэндийн	5	50	Нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсролыг дэмжих, бэлгийн замаар дамжих халдвар, итгэлтэй, найдвартай	100%

Д/д	Стратеги болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
			боловсролыг дэмжих сургалтын тоо			эмнэлгийн тусламжийг хаанаас авч болох тухай сэдвээр 249 сургалт зохион байгуулж, нийт 249 сургуулийн 2246 сурагчийг үе тэнгийн зөвлөгчөөр бэлтгэсэн. Үүнд: 1. Нийслэлийн харьяа дүүргийн эрүүл мэндийн байгууллагуудад бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн мэдлэг олгох, эмнэлгийн тусламжид чиглүүлж өгдөг байх чиглэлээр үе тэнгийн зөвлөгч бэлтгэх чиглэл өгсөний дагуу 9 дүүргийн эрүүл мэндийн төв, сонгинохайрхан нэгдсэн эмнэлгийн өсвөр үеийн кабинетын үйл ажиллагаагаар 1,480 үе тэнгийн зөвлөгчийг бэлтгэн сургалтад хамрууллаа. 2. "Өсвөр үеийнхнийг сонсёе, ойлгоё" сарын аяны хүрээнд бэлгийн бойжилт, болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, бэлгийн замын халдвар өвчнөөс сэргийлэх сэдвээр 766 үе тэнгийн зөвлөгч бэлтгэсэн байна.	8
	50. НТ-		Амны хөндийн эрүүл мэндийн сургалтад хамрагдсан эцэг эх асран хамгаалагчдын тоо	50,000	65,000	2025 онд 65056 эцэг эх, асран хамгаалагчид амны хөндийн эрүүл мэндийн боловсрол олгох сургалт, нөлөөллийн ажил явуулсан байна. Тухайлбал: - Эрүүл шүд арга хэмжээний хүрээнд Нийслэлийн Шүд эрүү нүүрний төв, дүүргийн эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлгүүдээр дамжуулан 0-18 насны хүүхдүүдэд зориулсан амны хөндийн эрүүл ахуйн сургалтыг 121 удаа зохион байгуулж, 13660 эцэг эх, асран хамгаалагчдыг хамруулсан. - Ерөнхий боловсролын сургуулийн 1 дүгээр ангид суралцаж буй 40,753 хүүхдийг урьдчилан сэргийлэх үзлэгт оруулахаас 2025 онд 33,310 хүүхдийг хамруулж, хамтран ажиллаж буй 86 эмнэлгийн эмчлэгч эмч нар урьдчилан сэргийлэх үзлэг болон эмчилгээнд хүүхдээ авчирсан 33,310 эцэг, эх, асран хамгаалагч нарт шүд угаах арга техник, шүдээ арчлах, шүдэнд ээлтэй хоол хүнс сэдвээр сургалтыг хийсэн. - Эрүүл мэндийн сайдын 2025 оны 03 сарын 11 өдрийн удирдамжийн дагуу "24/3 Шүдээ зөв угаа 2025" аяныг 15 төрлийн үйл ажиллагааны чиглэлээр зохион	100%

Д/д	Стратеги болон үндэслэл бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
						байгуулж, 18 байгууллагын 901 ажилтан албан хаагчийг хамруулсан Эрүүл мэндийн боловсрол олгох сургалт арга хэмжээнүүдийг зохион байгуулсан. - Эрүүл аюулгүй сургууль арга хэмжээний хүрээнд эрүүл мэндийн боловсрол олгох 200 удаагийн сургалтаар амны хөндийн арчилгаа сэдвээр сургалт зохион байгуулж, 15,400 эцэг эх асран хамгаалагчийг хамруулсан. - Тусгай хэрэгцээт иргэдийн “Эрүүл мэндийн өдөрлөг” зохион байгуулж ерөнхий боловсролын 7 сургууль, 1 цэцэрлэгийн хүүхдүүд болон тэдгээрийн эцэг эх асран хамгаалагчдад амны хөндийн эрүүл мэндийн боловсрол олгож, зөв дадал эзэмшүүлэх талаарх сургалтад 1623 эцэг эхийг хамруулсан. - Өргөө амаржих газар, ДЭМТ-үүдийн жирэмсний кабинетаар үйлчлүүлж буй 27 эх, төрөх тасагт хэвтэн эмчлүүлж буй 135 эхэд жирэмсэн болон хөхүүл үеийн амны хөндийн арчилгаа сэдвээр сургалт зохион байгуулсан.	
2.2.	Зорилтот бүлгийн нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдэд гэр бүл төлөвлөлтийн талаар мэдлэг, мэдээлэл олгох ажлыг эрчимжүүлж, жирэмслэхээс сэргийлэх арга хэмжээг нэмэгдүүлнэ.	30.0НТ-	Жирэмслэхээс сэргийлэх арга хэрэгсэлд хамрагдсан зорилтот бүлгийн эмэгтэйчүүдийн хувь	62	64	Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/11 дүгээр тушаалын дагуу нийслэлийн харьяа 9 дүүргийн эрүүл мэндийн төвд дүүргийн хэмжээнд нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн судалгааг сайжруулах чиглэл өгч шинэчлэн, нийт нөхөн үржихүйн насны 422,442 эмэгтэйчүүд, үүнээс 62,268 зорилтот бүлгийн эмэгтэйчүүд байна. 2025 оны 11 сарын 30-ны өдрийн байдлаар 41,987 зорилтот бүлгийн эмэгтэйг зөвлөгөө мэдээллээр хангаж, жирэмснээс сэргийлэх арга хэрэгслийн хамрагдалт 67,4% байна. Жирэмслэхээс сэргийлэх арга хэрэгслийг хэрэглэхийн ач холбогдол, гэр бүл төлөвлөлтийн аргуудыг таниулах, хүсээгүй жирэмслэлт, үр хөндөлтөөс сэргийлэх зорилгоор Нийслэлийн Засаг даргын 2025 оны “Нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх тухай” А/770 дүгээр захирамжийг батлуулж, жирэмслэхээс сэргийлэх арга хэрэгслийг таниулах хөтөч дэвтэр 28000 ширхгийг	100%

Д/д	Стратеги болон үндэслэл бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлгийн хувь
1	2	3	4	5	6	7	8
						боловсруулан гаргаж, 9 дүүргийн эрүүл мэндийн төвөөр дамжуулан мэдээлэл, сургалт, сурталчилгааны үйл ажиллагаанд ашиглаж байна. Дүүргүүдийн ЗДТГ, Боловсролын Ерөнхий газартай хамтран ажиллаж, 2025 оны 12-р сарын 15-ны өдрийн байдлаар МУБИС, МУИС, ДХИС, ХААИС, ШУТИС, УТИС, Оточ манрамба, МУИС, ИЗИС, ТЗИС, УБХИС, УБЭДС, БТДС, ТТДС, Мандах дээд сургууль зэрэг 14 их, дээд сургуулийн 14080 оюутанд нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол, мэдлэг хандлагыг дээшлүүлэх сургалтыг зохион байгуулсан. Мөн Налайх, Чингэлтэй, Хан-Уул, Баянзүрх, Баянгол, Сонгинохайрхан, Сүхбаатар дүүргийн тамгын газруудтай хамтарч, нөхөн үржихүйн эрүүл мэндийг хамгаалахад хэрхэн ажиллах, түүний ач холбогдол сэдвээр мэдлэг хандлага дээшлүүлэх 12 удаагийн сургалтад хороодын хэсгийн ахлагч, нийгмийн ажилтан нийт 1369 албан хаагчдыг хамруулсан.	
2.3.	Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлж буй албан хаагч нарт чиглэлийн давтан сургалтыг нэмэгдүүлнэ.	100.0 УТ	Сургалтад хамрагдсан албан хаагч-дын тоо	30	50	Харьяа эрүүл мэндийн байгууллагын нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлж буй 104 албан хаагчийг чиглэлийн давтан сургалтуудад хамруулсан. Тодруулбал: 1.Нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтнүүдийн нийгэмлэгээс зохион байгуулсан "Нийгмийн эрүүл мэндийн үндэс" сургалтад харьяа эрүүл мэндийн байгууллагын 32 албан хаагчийг, 2.НЭМУТ, НҮБ-ийн хүүхдийн сангаас "Эхийн хоол тэжээлийн тусламж үйлчилгээг сайжруулах" чиглэлээр сургагч багш бэлтгэх сургалтад НЭМГ-ийн хүнсний аюулгүй байдал, хоол тэжээл, амны хөндийн асуудал хариуцсан мэргэжилтэн болон 6 дүүргийн эрүүл мэндийн төвийн 23 албан хаагч, нөхөн үржихүйн зохицуулагч нарыг, 3.Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн "Өсвөр үеийнхэнд ээлтэй тусламж үзүүлэх анхан шатны эмч, мэргэжилтнүүдийг чадавхжуулах" сэдэвт сургалтад 3	100%

Д/д	Стратеги болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
						дүүргийн эрүүл мэндийн төвийн өсвөр үеийн тусламж үйлчилгээний зохицуулагч эмч, 46 өрхийн эрүүл мэндийн төвийн нийт 49 албан хаагч нарыг тус тус хамруулсан. Глобал сангийн дэмжлэгээр 2025-2026 онд эрүүл мэндийн байгууллагуудын удирдлага, нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн болон эмч, мэргэжилтнийг чадавхжуулах "Удирдах ажилтны 21 хоногийн сургалт"-д 27, "Анхан шатны эмнэлэгт ажиллаж буй нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтний мэргэжил дээшлүүлэх 3 сарын сургалт"-д дүүргийн эрүүл мэндийн төвийн 37, өрхийн эрүүл мэндийн 54 эмч, мэргэжилтний сургахаар нэрсийг гарган ЭМХТ-д хүргүүлэн бэлтгэл ажлыг хангасан байна. Мөн нийгмийн эрүүл мэндийн төвийг дүүрэг бүрд байгуулахтай холбогдуулан нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр тусламж үйлчилгээ үзүүлж байгаа албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэх хүсэлтийг ЭМЯ-нд хүргүүлсэн ба бодлогын баримт бичиг боловсруулагдаж хүлээгдлийн байдалд байна.	
2.4.	Нийслэлийн Нийгмийн эрүүл мэндийн салбар зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжижүүлнэ.	-	Салбар зөвлөлийн хурлын тоо	-	2	Эрүүл мэндийн Үндэсний зөвлөлийн 2018 оны "Нийслэлийн эрүүл мэндийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг батлах" тухай 01 дүгээр тогтоолоор Нийслэлийн Нийгмийн эрүүл мэндийн салбар зөвлөлийг байгуулсан. Тус тогтоолын дагуу НЭМГ-ын даргын 2025 оны "Ажлын алба байгуулах тухай" А/162 дугаар тушаалаар Нийслэлийн Нийгмийн эрүүл мэндийн салбар зөвлөлийн ажлын албыг байгуулсны дараагаар татан буулгах шийдвэр гарсан. Засгийн газрын 2025 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн 22 дугаар тогтоолоор Нийгмийн эрүүл мэндийн үндэсний зөвлөлийг татан буулгасан тул эрх зүйн хувьд боломжгүй болсон.	-
2.5.	Иргэдэд нийгмийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр	25.0 УТ	Зохион байгуулсан сургалтын тоо	25	250	2025 оны жилийн эцсийн байдлаар иргэдийн нийгмийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэхээр аж ахуйн нэгж байгуулллагад чиглэсэн сургалт 306 удаа, хүүхэд өсвөр	100%

Д/д	Стратеги болон төлөвлөгөө болон үндэслэлж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	8
	зохион байгуулна.					үеийнхэнд чиглэсэн сургалт 7006 удаа, иргэдэд чиглэсэн сургалт 1070 удаа тус тус зохион байгуулсан.	
		25.0 УТ	Хамрагдсан иргэд, аж ахуй нэгжийн тоо	250	2500	Та-лант хугацаанд нийгмийн эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлээр 306 удаагийн сургалтад 306 аж ахуйн нэгж, байгууллагын 7518 ажилтанг, сурагчдын нас хүйсийн онцлогт тохируулан 7006 удаагийн сургалтад 154,773 хүүхдийг, 1070 удаагийн сургалтад 70,000 гаруй иргэнийг хамруулсан. Үүнд: Нийслэлийн харьяа дүүргийн эрүүл мэндийн төвүүд Халдварт бус өвчнөөс сэргийлэх, түүний эрсдэлт хүчин зүйлийг бууруулах, Сүрьеэ өвчнөөс сэргийлэх, ДОХ/БЗДХ өвчин, түүнээс урьдчилан сэргийлэх, Эрүүл, зөв зохистой хослолт, Ахмадын эрүүл мэндийг дэмжих, эрүүл наслолт, Ундны усны эрүүл ахуй, Дархлаажуулалт, түүний ач холбогдол, Цочмог халдварт өвчин, түүнээс сэргийлэх, Өсвөр үеийнхний эрүүл мэнд, сэтгэцийн эрүүл мэнд, Хүн бүр аврагч, Эрт илрүүлэгт орох ач холбогдол, Мє-ингококкийн халдвараас сэргийлэх, Хорт зуршлаас сэргийлэх, Осол гэмтэлээс сэргийлэх, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрүүл мэнд, Ажлын байрны дасгал хөгсөлгөөн, Амны хөндийн эрүүл мэнд 24/3, Шүдээ зөв үгээ, Угаарын хийн хордлогоос сэргийлье зэрэг 18 сэдвээр нийт 1070 удаагийн сургалт зохион байгуулж 70 000 гаруй иргэнийг хамруулсан. Хүүхдэд бага наснаас нь нийгмийн эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл зан үйлийг төлөвшүүлж, сурагчдын нас хүйсийн онцлогт тохируулан нийт 7006 удаагийн эрүүл мэндийн боловсрол олгох сургалт зохион байгуулж, 154,773 хүүхдийг хамруулж ажиллаа. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн хариу арга хэмжээний бэлэн байдал, улаанбурхан өвчний үед хариу ар а хэмжээг шуурхай авах, дархлаажуулалтын хэ-бэрүүд, нөхөн дархлаажуулалт хийх журам, Томуу, тоцуу төст өвчин, менингитийн халдвараас урьдчилан сэргийлэх, осголт хөлдөлт, халтиргаа гулгаанаас	100%

Д/д	Стратеги болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
						сэргийлэх, хоолны хордлого, угаарын хийн хордлогоос сэргийлэх, Хүний папиллома вирусийн халдвар, түүний хор уршиг, умайн хүзүүний хорт хавдраас урьдчилан сэргийлэх, өвчлөлийг бууруулах зэрэг сэдвүүдээр 306 удаагийн сургалтад 7518 ажилтанг хамруулсан. Мөн тайлант хугацаанд хүн амын нийгмийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, халдварт болон халдварт бус өвчнийг бууруулах зорилгоор 8 удаагийн нөлөөллийн уулзалт хурал, 6 удаагийн арга хэмжээ, 4 удаагийн уулзалт хэлэлцүүлгийг зохион байгууллаа.	
2.6.	Зонхилон тохиолдох амьсгалын зам, гэдэсний бактерит, зоонозын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх боловсрол олгох үйл ажиллагааг зохион байгуулахаар "НЭМГ-ын НЭАХӨХ-ийн 2025 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө", "Зонхилон тохиолдох гэдэсний халдвар, хоол хүнс, ундны усаар дамжих өвчнөөс сэргийлэх, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээний төлөвлөгөө", "Зоонозын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, бэлтгэл бэлэн байдлыг хангах хариу арга хэмжээ авах" талаар харьяа эмч, ажилчдад зайны сургалт зохион байгуулах удирдамж зэрэг тусгайлсан төлөвлөгөө, удирдамжийн дагуу 18 арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллалаа. Тухайлбал: Зонхилон тохиолдох гэдэсний халдвар, хоол хүнс, ундны усаар дамжих өвчнөөс сэргийлэх, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээний хүрээнд Нийслэлийн дүүргүүдэд 2 аян, 1 өдөрлөг зохион байгуулсан. "Зонхилон тохиолдох гэдэсний халдвар, хоол хүнс, ундны усаар дамжих өвчин"-өөс сэргийлэх талаарх эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагууд нь 181 удаагийн мэдээлэл, сургалт сурталчилгааг, зохион байгуулахад 37525 иргэн, 151 байгууллага, аж ахуйн нэгж хамрагдсан. "Амьсгалын замын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх тухай" А/133 дүгээр	100.0 УТ	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	2	18		100%

Д/д	Стратеги болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
						захирамжийн дагуу 7 төрлийн зөвлөмж бүхий зурагт хуудас, 2 видео бичлэгийг түгээсэн. Мөн Нийслэлийн боловсролын газар, Нийтийн тээврийн бодлогын газарт 5 төрлийн бэлтгэсэн постер хүргүүлж, нийтийн 657 автобусанд байршуулж, цэцэрлэг сургуулийн орчинд байршуулж хамтран ажиллахыг хүсч иргэд олон нийтэд бүтээсэн. Харьга 28 эрүүл мэндийн байгууллага, 154 өрхийн эрүүл мэндийн төвүүдээс амьсгалын замын халдварт өвчнөөс сэргийлэх талаар 75 видео, 351 зурагт хуудас боловсруулж, хүлээлгийн танхимын дэлгэц, цахим болон тараах материал хэлбэрээр 246,545 хүнд мэдээлэл сурталчилгааг хүргэж, эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлж буй иргэдэд 39,453 маск тараасан. Эрүүл мэндийн байгууллагуудаас нийт 111 удаагийн сургалт зохион байгуулж, 14,339 сурагч, багш ажилчдыг хамруулсан. Амьсгалын замаар дамжих халдвараас сэргийлэх агуулга бүхий 370 гаруй зөвлөмж бүхий зурагт хуудас, видео боловсруулж, давхардсан тоогоор 1,310,000 гаруй хүнд хүргэсэн. Тархвар судлалын заалтаар балнад өвчнөөс сэргийлэх, тарилгад хамрагдах шаардлагатай нийслэлийн эрсдэлтэй ажил, мэргэжлийн 438 иргэний судалгаа гаргасан. Зоонозын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, бэлтгэл бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ авах талаар "Галзуу өвчний хяналт, сэргийлэлт", "Хачгаар дамжин халдварладаг өвчнүүдийн хяналт, сэргийлэлт" сэдэвт 2 чиглэлийн зайны сургалтыг тус тус зохион байгуулж нийт 160 эмч мэргэжилтнүүдийг хамруулсан. "Сүрьеэтэй тэмцэх дэлхийн өдөр"-ийг тэмдэглэх үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу 13 төрлийн үйл ажиллагааг тус тус зохион байгуулсан.	
2.7.	Сүрьеэ өвчний илрүүлэлтийг нэмэгдүүлж, өвчлөлийг бууруулна.	50.0 УТ	10,000 хүн амд ногдох илрүүлэлт /промиль/	7.9	21.4	2025 оны 11 сарын байдлаар шинээр илэрсэн сүрьеэгийн 1094 тохиолдол бүртгэгдэж 10,000 хүн амд 6.5 байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 75 тохиолдлоор /0.6	90.4%

Д/д	Стратеги болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
						промиль/буурсан байна. Нийт тохиолдлын 6.1 хувийг 0-14 насны хүүхэд эзэлж байна. Н-йслэлийн 9 дүүргийн сүрьеэгийн кабинетад нийт 88,553 үзлэг хийснээс, урьдчилан сэргийлэх үзлэг 54,793 буюу 61.8%-тай байна. Илрүүлэлтийн хувь 20.1 байна. НЭМГ-ын даргын баталсан "Сүрьеэтэй тэмцэх дэлхийн өдөр"-ийг тэмдэглэх үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу 13 төрлийн үйл ажиллагааг зохион байгуулан ажилласан бөгөөд, тайланг нэгтгэж ЭМЯ-д хүргүүлсэн. Тухайлбал: 1. Сүрьеэтэй тэмцэх дэлхийн өдрийг 2025.03.24-нд "ТИЙМЭЭ! БИД СҮРБЕЭГ УСТАЖ ЧАДНА" Амлалтаа хэрэгжүүлбэ, Хөрөнгө оруулья, Үйлчилгээг хүргэе! уриан дор тэмдэглэн өнгөрүүлсэн бөгөөд энэ хүрээнд ЭМЯ, ХӨСҮТ, ДЭМБ, ГЛОБАЛЬ САН, НЭМГ болон Дүүргийн эрүүл мэндийн төвийн сүрьеэгийн диспансерийн хамт олон болон төрийн бус байгууллагууд хамтран, Төв цэцэрлэгт хүрээлэнд нөхөрсөг тэмцээн, нээлттэй өдөрлөг зохион байгуулагдсан. 2. Эрсдэлт бүлгийн идэвхитэй илрүүлэлтийг зохион байгуулж 2025 оны 3 сард Багануур дүүрэгт 150 иргэнийг хамруулснаас 1 хуучин өвчилж байсан ба сүрьеэнийн сэжигтэй 7 хүнээс цэрний шинжилгээ авсан, 3. СХНЭ, СХД-ийн 26-р хорооны Засаг дарга, хэсгийн ахлагч нартай хамтран 5 сард Улаанчулуутын хогийн цэгт ажиллаж, хог түүдэг 43 иргэнийг үзлэгт хамруулснаас 10 хүн хуучин сүрьеэгээр өвчилж байсан ба сүрьеэгийн сэжигтэй 3 хүнээс цэрний шинжилгээ авсан 4. НЗДТГ, НЭМГ, СХНЭ-ийн сүрьеэ диспансер хамтран 2025 оны 3 сарын 27-ны өдөр НЗДТГ-ын нийт 112 ажилтанд сүрьеэ өвчний эрт илрүүлэг үзлэг зохион байгуулж, хэрхэн урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл бүхий гарын авлага, амны хаалт түгээж ажиллалаа. Үзлэгээр сүрьеэ сэжиглэгдсэн 9 хүний 2 нь хуучин өвдөөд	

Д/д	Стратеги болон үндэслэл байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
						эдгэрсэн байсан тул 5 хүнээс цэрний шинжилгээ авсан ба шинээр илэрсэн сүрьеэгийн тохиолдол байхгүй. 5. Налайх дүүргийн сургуулийн эмч эрүүл мэндийн хичээл заадаг багш нар болон өрхийн эмч, сувилагч нарын дунд Сүрьеэ өвчний тархалтын талаарх онолын мэдээлэл болон мэдлэг шалгах АХА тэмцээнийг 2 удаа зохион байгуулж чадавхжуулсан. 6. ЧДЭМТ, ХӨСҮТ-ийн СТСА-ны сэтгэлзүйн зөвлөгөө өгөх багийн сэтгэлзүйчтэй хамтарч сүрьеэ өвчнөөр өвдөж эмийн эмчилгээнд хамрагдаж байгаа 10 иргэнд зөвлөгөө өгч гарын авлага тараасан. 7. МУИС-ийн оюутан, багш нарт зориулж 3 сард эрт илрүүлэг үзлэг зохион байгуулж 63 иргэн хамрагдаж, 2 тохиолдол цэрний шинжилгээ авсан ба идэвхитэй сүрьеэ илрээгүй байна. 8. Баянзүрх дүүргийн хэмжээнд 3 сард сүрьеэ өвчний эрт илрүүлгийн аян зохион байгуулсан. 9. Баянгол дүүргий өрхийн болон хүүхдийн шинэ эмч (нийт 94 эмч) нарт "Сүрьеэ өвчин түүний оношлогоо эмчилгээний тухай", Сүрьеэгийн оношлогоо, сорьц цуглуулалт сэдвээр тус тус сургалт зохион байгуулж чадавхжуулсан. 10. 2024-2025 онд эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан сүрьеэгээр өвдөх эрсдэлт бүлгийн 3500 орчим хүний мэдээллийн /TUBIS/ санг шинэчилсэн бөгөөд тайлант хугацаанд тухайн зорилтот бүлгийн хүн амаас Энэрэл эмнэлэгт сүрьеэгийн амбулатороор 796 хүн үйлчлүүлсэн. Үүнээс амбулаторийн үзлэг 512, идэвхитэй хяналт 257, урьдчилан сэргийлэх үзлэг 136 байсан. Цээжний рентген зурагт 1645, цэрний түрхэцийн шинжилгээнд 297, Gene Хреп-ийн шинжилгээнд 295 хүн хамрагдсан байна. Нийт үзлэгт хамрагдсан 1600 орчим хүний рентген зургийг хиймэл оюун ухаан /ХОУ/-аар уншуулж, 204 хүнийг сэжиглэж, цэрний түрхэцээр 8 хүнийг батлан эмчилгээ, хяналтад авсан. ХОУ-аар сэжиглсэн 204 хүнийг эмнэлзүйн	8

Д/д	Стратеги болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
						эмч нарын хурлаар оруулсан. Түр болон байгын байлдагч 12 байгууллагын 247 хүнд Энэрэл эмнэлгийн эмч нарын хамтарсан үзлэг хийж 27 тохиолдлыг шинэ, болон дахилтаар илрүүлэн хяналтад авсан. Одоогоор /2025 оны 11 дүгээр сарын байдлаар/ Өлзийт асар, НХТТ, Батгэрэлт ирээдүй, Дөлгөөн минж, Жаргалан эдлэн, Өсвөрийн дуудлага гэсэн нийт 5 төрийн бус байгууллагад үргэлжлэх шатны эмчилгээ хийгдэж байна.	
		100.0 УТ	Шинээр илэрсэн халдварын эмчилгээний амжилтын хувь	79	84	Нийт 1094 шинэ тохиолдлоос эмчилгээнд хамрагдсан 1081 хүн буюу хамрагдалт 99% байна. Тайлант хугацаанд 597 хүн эмчилгээ дуусгаж, эдгэрэн хяналтаас гарсан ба сүрьеэгийн халдварын тохиолдлын эмчилгээний амжилт 80.1% байна. Эмчилгээний хамрагдалт болон амжилтыг нэмэгдүүлэх зорилгоор Чингэлтэй дүүгийн эрүүл мэндийн төв, ХӨСҮТ-ийн СТСА-ны сэтгэлзүйн зөвлөгөө өгөх багийн сэтгэлзүйчтэй хамтарч сүрьеэ өвчнөөр өвдөж эмийн эмчилгээнд хамрагдаж байгаа дүүргийн иргэдэд зөвлөгөө өгч гарын авлага тараасан.	78%
2.8.	БЗДХ-ийн илрүүлэлтийг нэмэгдүүлж, өвчлөлийг бууруулна.	50.0 УТ	10,000 хүн амд ногдох /промиль/	38.6	33.6	2025 оны 11 сарын байдлаар шинээр бэлгийн замаар дамжих халдварын 5,455 тохиолдол бүртгэгдэж 10,000 хүн амд 33.0 /промиль/ байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 288 тохиолдлоор /2.5 промиль/ буурсан байна. Нийт бэлгийн замаар дамжих халдварын 27.2 хувийг заг хүйтэн, 45.7 хувийг тэмбүү, 26.3 хувийг трихомониаз, 0.8 хувийг ХДХВ/ДОХ тус тус эзэлж байна. Нийт өвчлөлийн 14.7 хувийг 10-19 насныхан эзэлж байгаа нь өмнөх онтой харьцуулахад 1.0%-иар өссөн, төрөлхийн тэмбүүгийн тохиолдол 13 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4 тохиолдлоор өссөн байна.	100%
						НЗМГ-ын даргын 2025 оны А/94 дүгээр тушаалын дагуу "Хариуцлагатай сонголт" аяны хүрээнд өсвөр насны хүүхдийн бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн асуудал, охидын жирэмслэлт, төрөлт, бэлгийн замын	

Д/д	Стратеги болон үндэслэл бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлийн хувь
						7	8
1	2	3	4	5	6	хагдварт өвчин түүнээс урьдчилан сэргийлэх, хамтын ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр Налайх, Сүхбаатар, Баянгол дүүргийн хороодын нийгмийн ажилтан, ерөнхий боловсролын сургууль, их дээд сургуулийн эмч, нийгмийн ажлын туслах болон эх барих, эмэгтэйчүүдийн 39 хувийн хэргийн эрүүл мэндийн байгууллагын эмч, төлөөлөл нарын дунд 4 удаагийн уулзалт, хэлэлцүүлгийг нийт 168 хүнийг хамруулан зохион байгуулж, цаашид хамтран ажиллахаар төлөвлөсөн. ХД,КВ, ДОХ-ын асуудалд анхаарал хандуулах өдрийг 2025 онд "Асуудлыг шийдье, ДОХ-ын хариу арга хэмжээг сайжруулъя" уриан дор ЭМЯ-ны дэмжлэгтэйгээр Сонгинохайрхан нэгдсэн эмнэлэг дээр өдөрлөг зохион байгуулан тэмдэглэж, ЭМЯ, ДЭМБ, ХӨСҮТ, НЭМГ, СХНЗ болон иргэдийн төлөөлөл хүндэтгэлийн самбарт "Итгэлцлийн гарын үсэг" зурлаа. Тэмдэглэлт өдрийн хүрээнд харьяа эрүүл мэндийн байгууллагууд урьдчилан сэргийлэх үзлэг, мэдээлэл сургалтын үйл ажиллагааг зохион байгуулж 3149 иргэнд танхимын сургалт хийж, 2504 хүнийг сайн дурын шинжилгээнд хамруулж, цахим мэдээллүүд 28553 удаагийн хандалт авсан байна.	100% 100%
2.9.	Товлолт дархлаажуулалтын хамрагдалтыг нэмэгдүүлэх замаар тарилгаар сэргийлэгддэг халдварт өвчний тохиолдлыг бууруулна.	100.0 УТ	Товлолт дархлаажуулалтын хамрагдалтын хувь	95	96	Товлолт дархлаажуулалтын хамралтын мэдээг сар бүр тогтмол гарган ХӨСҮТ-ийн дархлаажуулалтын албанд хүргүүлж байна. 2025 оны эхний 11 сарын байдлаар Товлолт вакцины 17 тунгийн дархлаажуулалтад давхардсан тоогоор 469,918 хүүхэд хамрагдахаас 435,334 хүүхэд хамрагдаж хамралтын дундаж 92.6% байна. Үүнд: 1.ЕЦЖ (1 тун) – 99.5% 2.Гэлатит В (1 тун) – 99.3%	0%

Д/д	Стратеги болон үндэслэл байдга бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
						3.Саа (4 тун) – 95,1% 4.Тавт (3 тун) – 95,3% 5.УГУ (2 тун) – 97,1% 6.Гепатит А (2 тун) – 95,0% 7.Пневмококк (3 тун) – 95,3% 8.Сахуу-татран (2 тун) – 74,0% байна. 2025 оны эхний 11 сарын байдлаар Хүний папиллома вирус (1тун) дархлаажуулалтын хамрагдалт – 50.0%-д хүрсэн. Хүний папиллома вирусын эсрэг вакциныг “Дархлаажуулалтын үндэсний төвлөл”-д шинээр нэвтрүүлсэнтэй холбогдуулан дархлаажуулалтын хамрагдалтыг нэмэгдүүлэх арга хэмжээнүүдийг зохион байгуулан ажиллаж байна. Тухайлбал: Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/1256 дугаар захирамж, Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын “Хүний папиллома вирусийн эсрэг дархлаажуулалтыг нийслэлд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах тухай” А/168 дугаар тушаал, “Хүний папиллома вирусийн халдварын эсрэг вакцинаар дархлаажуулах тухай” А/179 дүгээр тушаалуудыг гарган хэрэгжилтийг хангасан. НЭМГ-ын даргын 2025 оны А/29 дүгээр тушаалаар нийслэлийн ЕБС-иудын дунд “Эрүүл чийрэг өсвөр үе” аян, нийслэлийн анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын дунд “Зорилтот насны хүүхдийн нөхөн дархлаажуулалтыг эрчимжүүлэх аян”-ыг тус тус зохион байгуулсан. Аяны хүрээнд 6 сургууль, 4 ӨЭМТ шалгарч, 3,084 иргэнд мэдээлэл, зөвлөгөөг өгч ажилласан байна. Мөн НЭМГ-ын даргын 2025 оны “Хүний папиллома вирусийн халдварын эсрэг дархлаажуулалтыг эрчимжүүлэх тухай” А/321 дүгээр тушаалын дагуу НҮБ-ийн Хүүхдийн сантай хамтран Нийслэлийн төрийн, хувийн өмчийн сургуулиудын 325 эмч, мэргэжилтэнг сургалтад хамруулсан.	

Д/д	Стратеги болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
2.10	Тархвар судлалын заалтаар хийгддэг өвчний эсрэг дархлаажуулалтыг нэмэгдүүлэх замаар халдварт өвчний тохиолдлыг бууруулна.	100.0 УТ	Товлолт бус дархлаажуулалтын хамрагдалтын хувь	95	96	Нийслэлийн хэмжээнд тархвар судлалын заалтаар хийгддэг товлот бус дархлаажуулалтын хамрагдалт 98.03%-тай байна. Үүнд: Нийслэлд менингитийн халдвар 2025 оны 1 дүгээр сард 1, 11 дүгээр сард 1 тохиолдол бүртгэгдсэнтэй холбоотой Эрүүл мэндийн сайдын 2025 оны "Менингококкт халдварын бэлэн байдал, эмчилгээ, ялган оношилгоо, хариу арга хэмжээг эрчимжүүлэх тухай" 01 дүгээр албан даалгаврын хүрээнд НЭМГ-ын даргын "Менингококкт халдварын бэлэн байдал, эмчилгээ, ялган оношилгоо, хариу арга хэмжээг эрчимжүүлэх төлөвлөгөө - 2025 он"-ыг гарган харьяа 27 байгууллагад хүргүүлж, тэдгээрийн хэрэгжилтийн талаарх мэдээллийг 7 хоногийн Даваа гараг бүр ubhd.mad@gmail.com цахим хаягаар авч ажилласан. Батлагдсан нэг, нас барсан нэг тохиолдлын голомтын дархлаажуулалтад тархвар судлалын заалтаар 28 хүнийг 100 хувь хамруулсан. Монгол Улсад Улаанбурхан өвчний тохиолдол бүртгэгдсэнтэй холбоотой голомтын болон нэмэлт дархлаажуулалтын үйл ажиллагаа эхэлсэн. Улсын Онцгой Комиссын комиссын 2025 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн 02 дугаар хуралдааны тэмдэглэл, Улсын Онцгой комиссын комиссын 2025 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 01 дүгээр тогтоол, Шадар сайдын 2023 оны "Журам шинэчлэн батлах тухай" 28 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын 2025 оны "Улаанбурхан өвчний үеийн хариу арга хэмжээг эрчимжүүлэх тухай" А/223 дугаар тушаал, Нийслэлийн онцгой комиссын 2025 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 02 дугаар хурлын шийдвэр, Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын 2025 оны "Тохиолдлын удирдлагын тогтолцоогоор ажиллах тухай" А/154 дүгээр тушаалын дагуу дархлаажуулалтад 10 сартайгаас 15 насны 119,973 хүн хамрагдахаас 72164 хүн хамрагдаж, хамралт 60%-тай байна. Мөн улаанбурхан өвчний 10797 тохиолдол батлагдсанаас 73768 хавьтлаас голомтын	100%

Д/д	Стратеги болон үндэслэл бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
						дөрхлөхжүүлалтад 47649 хүн хамрагдаж, хамралт 96%-тай байна.	
						Нийслэлийн хэмжээнд томуугийн эсрэг дархлаажуулалтад 146853 эрсдэлт бүлгийн хүн ам хамрагдахаас 143753 хамрагдаж, хамралт 98.1%-тай байна	
			Хамтран ажилласан хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын тоо	30	50	"Эрүүл шүд" арга хэмжээний хүрээнд дүүргийн эрүүл мэндийн төв, Өрхийн эрүүл мэндийн төвүүд хувийн хэвшлийн 85 шүдний эмнэлэгтэй хамтран, сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын хүүхдүүдийн амны хөндийд урьдчилан сэргийлэх эрт илрүүлгийн үзлэгийг хийж байна.	100%
2.11	"Эрүүл шүд" арга хэмжээг хэрэгжүүлж, төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд сургуулийн өмнөх боловсролын болон байгууллагын ерөнхий боловсролын сургуулийн суралцагсдыг амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж эрүүлжүүлнэ.	-	Урьдчилан сэргийлэх үзлэгт орсон хүүхдийн тоо	40,000	40,000	2025 оны жилийн эцсийн байдлаар урьдчилан сэргийлэх үзлэгт ЕБС-ийн 1 дүгээр ангийн 40,753 хүүхэд хамрагдах ёстойгоос 33,310 хүүхэд буюу 81.7% нь хамрагдаад байна. Үүнээс зүрхний үзлэгт 33,918, шүдний үзлэгт 33,310 , нүдний үзлэгт 28,318 хүүхэд тус тус хамрагдсан. Энэхүү эрт илрүүлгийн үзлэгийг 2025 оны 7 дугаар сараас зогсоосон.	100%
			Эмчилгээнд хамрагдаж эрүүлжсэн хүүхдийн тоо	8000	20,000	Дүрэг, өрхийн эрүүл мэндийн төвөөс сургуулийн өмнөх бсловсролын байгууллага, ерөнхий боловсролын сургуулиудад хийсэн шүдний үзлэгт 8549 хүүхдийг хамруулсан. Тайлант онд 41859 хүүхдийг шүдний урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан байна.	84%

Д/д	Стратеги болон үндэслэл байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
						хэлэлцүүлгээр жирэмсний хяналтад ороогүй, ургийн гажиг илэрсэн, аргаг суурь өвчлөлтэй жирэмсэн эхийн мэдээллийг солилцох шийдэлд хүрсэн. 2. Жирэмсний эрт хяналтыг сайжруулах зорилгоор ЭМС-ын 2024 оны A/292 дугаар тушаалын дагуу нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн судалгааг шинэчлэн аргаг ажлыг зохион байгуулсан. 3. Ургийн хромосомын гажиг илрүүлэх жирэмсний эхний 3 сарын нийлмэл илрүүлэг шинжилгээг хийх бэлтгэл ажлыг ханган жирэмсний эхний 3 сарын ЭХО хийх чадамжтай албан ёсны сертификаттай 16 эмч (3 амаржих газарт 9, дүүргийн ЭМТ-д 7)-ийг бэлтгэсэн. Хоёрлол төстийн шинжилгээг Нийслэлийн Өргөө амаржих газар хийж эхэлсэн. 4. Ургийн гажгийг илрүүлэх 4D ЭХО-оор 8 (БГДЭМТ, СХДЭМТ, БНДЭМТ, СБДЭМТ, ХДУЭМТ, СХНЭ, СБНЭ, ХАГ) байгууллагыг хангаж 10 сарын байдлаар 4189 жирэмсэн эмэгтэйд ургийн бүтцийн гажгийн илрүүлэг, оношилгоо хийж 12 ургийн гажиг илрүүлээ. 5. Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндсэн үзүүлэлтэд дүн шинжилгээ хийж, 2025 оны 01 сард 01/74 тоот албан бичгээр харьяа эрүүл мэндийн байгууллага, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд чиглэл хүргүүлэн хяналт тавьлаа. 6. "Эхийн эндэгдэл, түүнд нөлөөлсөн хүчин зүйл, давтан гарахаас сэргийлэх нь" хэлэлцүүлгийг 5 сард, "Тав хүртэлх насны хүүхдийн тусламж үйлчилгээний хожимдол түүнд нөлөөлсөн хүчин зүйл, давтан гарахаас сэргийлэх нь" хэлэлцүүлгийг 3 болон 5 сард тус тус зохион байгуулсан. 7. Эх, хүүхдийн эндэгдэл, тусламж үйлчилгээг сайжруулах зорилгоор Нийслэлийн Эрүүл мэндийн газраас "Хариуцлагатай сонголт" аяныг зохион байгуулж, 3 зорилтын хүрээнд 18 үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. 8. "Жирэмсэн эхийн эрэмбэлэн ангилалт яаралтай тусламж үйлчилгээг сайжруулах" зорилгоор 5 сард Нийслэлийн түргэн тусламжийн төвийн эмч нарыг амаржих газруудад	

Д/д	Стратеги болон үндэслэл бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
						дадлага сургалтад, 2 сард төвийн 3 дүүргийн эрүүл мэндийн төвийн эх барих эмэгтэйчүүдийн 7 эмчийг мөн дадлага сургалтад хамруулж ур чадварыг сайжруулсан. 9."Гэр бүл төлөвлөлийн урт хугацааны аргуудыг тавих ба авах арга техникт сургах нь" сургалтыг MSI reproductive Choices ОУБ, Women care global international байгууллагатай хамтран 9 сард зохион байгуулж 22 эмч, эх баригчийг чадавхжуулсан. 10.Нийслэлийн хэмжээнд эхийн, перинатал (нярай) эндэгдлийг тогтвортой бууруулах, үзүүлэх тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, хүртээмжийг тасралтгүй сайжруулах үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах зорилгоор НЭМГ-ын даргын 2025 оны А/265 тушаалаар батлагдсан хорооны гишүүдийг олон улсын жишигт нийцсэн арга зүйн сургалтад хамруулсан. 11."Тохиолдолд суурилсан цахим хэлэлцүүлэг"-ийг 9 удаа хийж давхардсан тоогоор 3600 эмчийг хамруулсан.	
			TORCH/ шинжилгээний үйл ажиллагаа тогтмолжсон лабораторийн тоо	1	3	Харьяа 7 эрүүл мэндийн байгууллага нь (БЗДЭМТ, БГДЭМТ, НДЭМТ, СХДЭМТ, ХУДЭМТ, ЧДЭМТ, Өргөө амаржих) нь эхээс урагт дамжих халдвар илрүүлэх TORCH шинжилгээг иммунологийн аппаратаар Электрохимилуминесценц аргаар хийдэг. 2023, 2024 онд Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны "Жагсаалт батлах тухай" А/53 дугаар тушаал дахь тарифын дагуу нэхэмжилж санхүүжиж байсан. Гэвч Эрүүл мэндийн даатгалын Ерөнхий газрын даргын 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн "Жагсаалт батлах тухай" А/150 дугаар тушаал шинэчлэгдэн батлагдаж уг тушаалд TORCH шинжилгээнээс зөвхөн Улаанууд /Rubelle/ вирусийн халдварыг илрүүлэх шинжилгээг оруулсан бөгөөд бусад халдвар илрүүлэх шинжилгээг оруулаагүйгээс санхүүжилтгүй болж цаашид TORCH шинжилгээг ЭМД-ын санхүүжилтээр хийх боломжгүй болсон.	100%

Д/д	Стратеги болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
						Энэхүү шинэчилсэн тушаалтай холбогдуулан 2025 оны 04 сарын 04-ны өдөр "Нөхөн үржихүйн эрүүл мэнд, оношилгоо, шинжилгээ" сэдэвт хэлэлцүүлгийг харьяа 9 дүүрэг, амаржих газрын лабораторийн эрхлэгч, нөхөн үржихүйн зохицуулагч нарын дунд зохион байгуулж, нийт 17 эмч, мэргэжилтэнг оролцуулсан санал солилцсон. Уг хэлэлцүүлгийн үр дүнд Улаанууд вирусээс бусад үзүүлэлт болох херпес вирус, цитомегаловирус, токсоплазма гонди шимэгчийн халдвар илрүүлэх шинжилгээний санхүүжилтийг даатгалд оруулах саналыг Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 01/1089 тоот албан бичгээр Эрүүл мэндийн даатгалын Ерөнхий газарт хүргүүлэн ажилласан боловч эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн асуудлын улмаас шийдвэрлэгдээгүй байна.	
2.15	Анхан шатны эрүүл мэндийн байгууллагад шүдний тусламж, үйлчилгээг нэвтрүүлнэ.	400.0 УТ	Шинээр тусламж үйлчилгээ нэвтрүүлсэн байгууллагын тоо	-	10	Анхан шатны эрүүл мэндийн байгууллага болох Гачуурт, Жаргалант, Хонхор, Туул тосгоны Эрүүл мэндийн төвд шүдний тусламж үйлчилгээг нэвтрүүлж, 2,228 хүнд үзлэг хийж, эрүүлжилт 78%-тай байна. Шүдний тусламж үйлчилгээг 2025 онд анхан шатны эрүүл мэндийн байгууллагад нэмж нэвтрүүлэхэд шаардагдах 13 төрлийн 149 ш нийт 1,178,915,000 төгрөгийн төсөв, тоног төхөөрөмж худалдан авах саналыг 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдөр ЭМЯ-нд хүргүүлсэн боловч төсөв шийдэгдээгүй байна. Нийслэлийн 151 өрхийн эрүүл мэндийн төв нь хувийн хэвшлийн шүдний эмнэлэгтэй хамтран 6 настай 33,310 хүүхдэд амны хөндийн өвчлөлийн эрт илрүүлэх үзлэгийг зохион байгуулж 12,446 хүүхдийг эмчлэн эрүүлжүүлсэн.	100%
2.16	Эхийн сүүний амаржих газруудыг түшиглэн байгуулна.	30.0НТ	Эхийн сүүний банк байгуулсан амаржих газрын тоо	-	1	Нийслэлийн Өргөө амаржих газар "Эхийн сүүний банк" ажиллуулах өрөөг тохижуулж сүү хадгалахад шаардлагатай 3 зориулалтын хөргөгчийг байршуулж, эх барих, нярайн эмч, эх баригч, сувилагч нийт 4 эмнэлгийн мэргэжилтнийг эхийн сүүний сургагч багшаар бэлтгэн	100%

Д/д	Стратеги болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
						эхийн сүүний банкыг байгуулсан. 2025 оны байдлаар 32 нярайг эхийн сүүний банк ашиглаж хооллосон байна. UNICEF-ийн дэмжлэгтэйгээр эхийн сүүний нөөцийн банк байгуулах төсөл хэрэгжиж эхлэн 2025 оны 5 сард олон улсын зөвлөх эмч нарын сонгон шалгаруулалт дуусч, Их британи улсын хөхний сүүний банкны зөвлөх Hoang Tran Deputy Director of Da Nang Hospital for Women and Children cum Head of Da Nang Human Milk Bank, Gilian Weaver Co-founder European Milk Bank Association & Human Milk Foundation Global Alliance of Milk Banks and Associations, Duong Vu Viet Nam Program Manager Regional Technical Specialist Alive & Thrive, FHI 360 эмч нар сонгогдон 2025 оны 08 сарын 18-нд Нийслэлийн Амгалан амаржих газарт 5 хоног ажиллан Өргөө амаржих газар, ЭХЭМҮТ-тэй танилцсан. ЭМЯ, ЭМДЕГ, НЭМГ, төрөх эмнэлгүүдийн мэргэжилтнүүдтэй хэлэлцүүлэг хийгдэж Амгалан амаржих газар "Эхийн сүүний нөөцийн банк" байгуулахаар сонгогдсон. Нийслэлийн Амгалан амаржих газар нь "Эхийн сүүний банк" ажиллуулах 3 өрөө, эхийн сүүний сургагч 2 багшийг бэлтгэж, нийт ажилчдад "Эхийн сүү"-ний сургалтыг 1 удаа зохион байгуулж бэлтгэл ажлыг хангаад байна.	8
2.17	Бага насны хүүхдийн суурь өвчлөл хоол тэжээлийн цочмог дутлыг илрүүлэн, эрүүлжүүлэх, урьдчилан сэргийлэх замаар эндэгдлийг бууруулна.	-	Эрүүлжилтийн хувь	92	92.5	2025 оны 10 сарын байдлаар 8 дүүргийн эрүүл мэндийн төв, 5 нэгдсэн эмнэлэг, 3 хүүхдийн сэргээн засах төв, өрхийн эрүүл мэндийн төв, тосгоны эрүүл мэндийн төвүүдээр дамжуулан 0-5 насны 176,523 хүүхдийг давардсан байдлаар 568,236 удаа өсөлт хөгжлийн хяналтад хамруулсан. Өсөлт хөгжлийн хяналтын үзлэгээс туранхай 736 , тураалтай 578 , өсөлтийн хоцрогдолтой 742 , цус багадаалттай 1456 , сульдаатай 896 хүүхдийг илрүүлэн өрхийн эрүүл мэндийн төв, хүүхдийн сэргээн засах төвүүдээр дамжуулан 100% хяналтад авч эмчилж, эрүүлжүүлэн ажиллаж байна.	100%

Д/д	Стратеги болон үндэслэл байдга бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлгийн хувь
1	2	3	4	5	6	7	8
2.18	Эрт нярайн тархи хөргөөх эмчилгээг амаржих газарт нэвтрүүлнэ.	300.0 НТ-	Шинээр тусламж үйлчилгээг нэвтрүүлсэн амаржих газрын тоо	-	1	Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/531 дүгээр тушаалын хүрээнд нийслэлийн 3 амаржих газар шаардлагатай аппаратаар хангагдаж, "Эрт нярайн тархи хөргөх эмчилгээ"-г шинээр нэвтрүүлсэн. 2025 оны 10 сарын байдлаар Нийслэлийн Хүрээ амаржих газар 1, Өргөө амаржих газар 16 нярайд эрт нярайн тархи хөргөх эмчилгээг хийсэн байна.	100%
2.19	Дутуу төрсөн 2500 граммаас дээш жинтэй нярайн амьсгалыг үргэлжилсэн өндөр давтамжаар амьсгал аппаратаар удирдах эмчилгээг амаржих газарт нэвтрүүлнэ.	350.НТ	Шинээр тусламж үйлчилгээг нэвтрүүлсэн амаржих газрын тоо	-	1	Нийслэлийн хөрөнгө оруулалтаар 2025 онд нийслэлийн Өргөө амаржих газарт "Дутуу төрсөн 2500 граммаас дээш жинтэй нярайн амьсгалыг үргэлжилсэн өндөр давтамжаар амьсгал аппаратаар удирдах" эмчилгээнд шаардлагатай аппарат тоног төхөөрөмжөөр хангасан. Нийслэлийн Амгалан, Хүрээ, Өргөө амаржих газар "Дутуу төрсөн 2500 граммаас дээш жинтэй нярайн амьсгалыг үргэлжилсэн өндөр давтамжаар амьсгал аппаратаар удирдах" эмчилгээг шинээр нэвтрүүлсэн. 2025 оны 10 сарын байдлаар Амгалан амаржих газарт 16, Хүрээ амаржих газарт 13, Өргөө амаржих газарт 36 нярайг тус аппаратад оруулсан.	100%
2.20	Дүүргийн эрүүл мэндийн төвийг Нэгдсэн эмнэлэг, Нийгмийн эрүүл мэндийн төв болгон өөрчлөх бэлтгэл ажлыг хангана.	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	-	30	Дүүргийн эрүүл мэндийн төвийг Нэгдсэн эмнэлэг, Нийгмийн эрүүл мэндийн төв болгон өөрчлөх бэлтгэл ажлыг хангах хүрээнд Дүүргийн эрүүл мэндийн төвүүдээс барилга байгууламж, хүн хүч, тоног төхөөрөмжийн судалгааг авч нэгтгэн ЭМЯ-д хүргүүлсэн. ЭМЯ-аас Нийгмийн эрүүл мэндийн төв байгуулах тушаал, бүтцийн болон ажиллах журам, санхүүжилтийн асуудал шийдэгдээгүй байгаа тул дүүргийн эрүүл мэндийн төвийг нийгмийн эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлэг болгон өөрчлөх үйл явц хүлээлтийн байдалтай байна.	-
2.21	Эрүүл мэндийн ажилтны сурч хөгжих боломжийг нэмэгдүүлнэ.	-	Сургалтад хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтний тоо	2341	2500	Нийслэлийн харьяа 28 эрүүл мэндийн байгууллагууд ажлын байран дээрх болон танхимын мэргэшүүлэх сургалтад давхардсан тоогоор 2610 эмч, ажилтнуудыг хамруулан ур чадварыг дээшлүүлэн чадавхжуулсан. Үүнээс нийт сургалтын 92.8% нь ажлын байран дээр дадлагажуулах, ажилтны мэдлэг ур чадварыг дээшлүүлэх	100%

Д/д	Стратеги болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
						сургалт ихэнх хувийг эзэлж байгаа. 3.6%-ийг Хууль эрх зүй, ёс зүйн чиглэлийн сургалт, 3.6% Хувь хүнийг хөгжүүлэх чиглэлийн сургалтууд эзэлж байна. Нийслэлийн харьяа Эрүүл мэндийн байгууллагуудаас БНХАУ-ын ӨМӨЗО-ны Олон улсын Монгол эмнэлэгт Уламжлалт анагаах ухаан, сэргээн засал судлалын 38 эмч сонгогдон 6 хоногийн, Хята- Монгол Уламжлалт эмнэлэгт 10 эмч 7 хоногийн хугацаатай сургалтад хамрагдсан. Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн хөгжлийн төв хамтран Японы "ЖАЙКА" Олон Улсын байгууллагын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй "Шинэ сувилагч, шинэ эх баригчийн сургалтын хөтөлбөр"-ийг нийслэлийн харьяа 5 байгууллага /СХНЗ, БЗДЭМТ, НХАГ, НӨАГ, СБДЭМТ/ 6 сувилагч тус хөтөлбөрт хамрагдсан. Нийслэлийн харьяа Эрүүл мэндийн байгууллагуудаас улсын төсвийн санхүүжилтээр Төгсөлтийн дараах төрөлжсөн мэргэшил болон мэргэжил дээшлүүлэх сургалтад 2025-2026 оны хичээлийн жилийн хаврын элсэлтийн сургалтад 80 эмч, 72 сувилагч, тусгай мэргэжилтний сургалтын захиалга хүргүүлснээс 30 эмч, 34 сувилагч, тусгай мэргэжилтэн төгсөлтийн дараах төрөлжсөн, дээшлүүлэх хаврын сургалтад хамрагдаж байна. "2025-2026 оны Төгсөлтийн дараах сургалтын чиглэл, элсэлтийн хяналтын тоо, сургалтын зардал батлах тухай" Эрүүл мэндийн сайдын А/433 дугаар тушаалын хүрээнд Эрүүл мэндийн ажилтны 2025-2026 оны төгсөлтийн дараах сургалтын чиглэл Улсын төсвийн санхүүжилтээр төгсөлтийн дараах үндсэн мэргэшил, төрөлжсөн мэргэшил болон мэргэжил дээшлүүлэх сургалтад, 2025-2026 оны хичээлийн жилийн намрын элсэлтийн сургалтад 12 эмч, сувилагч, тусгай мэргэжилтэн хамрагдсан мөн 1 сарын дархлаажуулалтын сувилахуйн сургалтад 29 сувилагч хамрагдаж төгссөн.	

Д/д	Стратеги болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
2.22	Нийслэлийн мэндийн байгууллага, ажилчдын ажлын гүйцэтгэлийг үр дүнгээр тооцон урамшуулал олгоно.	400.0 НТ	Шалгаруулсан байгууллага, ӨЗМТ-ийн тоо	15	15	Нийслэлийн харьяа шилдэг эрүүл мэндийн байгууллага, шилдэг эмч, сувилагч, тусгай мэргэжилтэн, ажилтанд олгох Нийслэлийн Засаг даргын 2025 оны "Мөнгөн урамшуулал олгох" А/1600 дугаар захирамжийг батлуулж, захирамжийн хүрээнд газрын даргын 2024 оны А/172 дугаар тушаалаар батлагдсан квотын дагуу шилдэг эрүүл мэндийн байгууллагад 11, шилдэг Өрхийн эрүүл мэндийн төвд 12, шилдэг тусгай мэргэжлийн ангилалд 6 байгууллага өрсөлдөхөөр материал ирүүлснээс Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/881 дүгээр захирамжаар батлагдсан үйл ажиллагааны үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлтийн дагуу Шилдэг Өрхийн Эрүүл мэндийн төв 6, Шилдэг эрүүл мэндийн байгууллагад 6, шилдэг тусгай мэргэжлийн эрүүл мэндийн байгууллага 3 тус тус шалгарч нийт 15 байгууллагад, цом, мөнгөн урамшууллыг олгосон.	100%
			Шалгаруулсан эмч, эмнэлгийн мэргэжилтний тоо	164	164	Эрүүл мэндийн шилдэг байгууллага, эмнэлгийн шилдэг мэргэжилтэн, эрүүл мэндийн шилдэг ажилтан шалгаруулах журмын дагуу нийслэлийн харьяа 28 эрүүл мэндийн байгууллагаас 2-р шатны сонгон шалгаруулалтаас шалгарсан эмч 67, сувилагч, тусгай мэргэжилтэн 65, бусад ажилтан 54 нийт 186 эрүүл мэндийн салбарын ажилтнуудад өргөмжлөл, мөнгөн урамшууллыг олгосон.	100%
Зорилт 3. Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд: Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлж, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлж, авлигаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ. /АХ-1.3.10, 2.2.21, МУХЖТ-1.3.1, 2.2.1/							
3.1.	Нийслэлийн мэндийн стратеги боловсруулсан батлуулна.	-	Батлуулсан стратеги төлөвлөгөө-ний тоо	-	1	Нийслэлийн эрүүл мэндийн газрын даргын А/124 тушаалаар стратеги төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэг байгуулагдан "Нийслэлийн Эрүүл мэндийн салбарын 2025-2028 оны стратеги төлөвлөгөө" -боловсруулан байгууллагын удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлсэн.	70%

Д/д	Стратеги болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
						"Нийслэлийн Эрүүл мэндийн салбарын 2025-2028 оны стратеги төлөвлөгөө"-г батлуулахаар НЗДТГ-т хянуулж байна.	
3.2.	Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлаар тодорхой асуудлыг төлөвлөн хэлэлцүүлэх, түүнийг хэрэгжүүлэх, тайлагнана.	-	Хэлэлцүүлсэн асуудлын тоо	-	1	Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдаанд Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Уламжлалт анагаах ухааны элэг судлалын клиник төвийн үйл ажиллагааг зогсоож, түүний эрх үүрэг, хариуцлагыг Сонгинохайрхан нэгдсэн эмнэлэгт нэгтгэн өөрчлөн байгуулах талаар хэлэлцүүлж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэхийг НЗД-ын зөвлөлийн 08 дугаар хуралдааны тэмдэглэлээр үүрэг болгосон. Үүрэг даалгаврын хүрээнд 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж, НИТХ-ын 2025 оны 25/77 дугаар тогтоолоор Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Уламжлалт анагаах ухааны элэг судлалын клиник төвийн үйл ажиллагааг зогсоож, түүний эрх, үүрэг, хариуцлагыг Нийслэлийн Эрүүл мэндийн газрын харьяа Сонгинохайрхан нэгдсэн эмнэлэгт нэгтгэн өөрчлөн байгуулсан шийдвэр гарсан.	100%
3.3.	Улс, нийслэлийн дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт туслуулах санал боловсруулж хүргүүлнэ.	-	Боловсруулсан саналын тоо	3	3	1. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 12 арга хэмжээг хэрэгжүүлэхээр саналыг Нийслэлийн Засаг даргын тамгын газарт хүргүүлсэн. 2. Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний төсөлд Эрүүл мэндийн салбарын хэрэгжүүлэх 6 арга хэмжээний саналыг боловсруулан Нийслэлийн Засаг даргын тамгын газарт хугацаанд хүргүүлсэн. 3. Нийслэлийг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг боловсруулах ажлын бэлтгэл хангахтай холбогдуулан байгууллагын саналын төслийг 2025 оны 10-р сарын 20-ны өдрийн "Санал хүргүүлэх тухай" 5/2485 тоот албан бичгээр Нийслэлийн Засаг даргын тамгын газарт хүргүүлсэн.	100%

Д/д	Стратеги болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
3.4.	Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн төлөвлөгөө, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2025 оны хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, ЗДТГ-т хүргүүлнэ.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт тоогоор	2	2	Тайлант хугацаанд 4 удаа тайлагнасан. "Нийслэлийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн эрүүл мэндийн салбарын хэрэгжүүлэх 7 зорилт 12 арга хэмжээний 2025 оны хэрэгжилтийн хагас жилийн тайланг 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдөр НЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний газарт ERP системээр, жилийн эцсийн хэрэгжилтийн тайланд дүн шинжилгээ хийж 2025 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр НЗДТГ-ын Нийслэлийн бодлого, төлөвлөлтийн газарт албан бичгээр тус тус хүргүүлсэн. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн эрүүл мэндийн салбарын хэрэгжүүлэх 8 зорилт 18 арга хэмжээний 2025 оны хэрэгжилтийн хагас жилийн тайланг 2025 оны 08 дугаар сарын 15-ны өдөр НЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний газарт, жилийн эцсийн хэрэгжилтийн тайланд дүн шинжилгээ хийж 2025 оны 12 дугаар сарын 02-ны өдөр НЗДТГ-ын Нийслэлийн бодлого, төлөвлөлтийн газарт тус тус албан бичгээр хүргүүлсэн.	100%
3.5.	Нийслэлийг хөгжүүлэх 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, ЗДТГ-т хүргүүлнэ.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт тоогоор	2	2	Тайлант хугацаанд 2 удаа тайлагнасан. Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний эрүүл мэндийн салбарын хэрэгжүүлэх 42 арга хэмжээний хэрэгжилтийн хагас жилийн тайланг 2025 оны 06 дугаар 26-ны өдөр, жилийн эцсийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж 2025 оны 12 дугаар сарын 02-ны өдөр тус тус албан бичгээр НЗДТГ-т хүргүүлэн тайлагнасан.	100%
3.6.	Нийслэлийн Засаг даргын "2025 оныг Бүтээн байгуулалтын жил болгон зарлах тухай" 01 дүгээр захирамжийн дагуу бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх	-	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	-	100	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч 2025 оны А/01 дүгээр захирамжаар "Бүтээн байгуулалтын жил" болгон зарласантай холбогдуулан бүтээн байгуулалтын 2025 оны төсөл, арга хэмжээний ажлын календарьчилсан төлөвлөгөө батлагдсан. Тус төлөвлөгөөнд тусгагдсан эрүүл мэндийн салбарын хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг 2025 оны жилийн эцсийн байдлаар нэгтгэж, Нийслэлийн Засаг	100%

Д/д	Стратеги болон үндэслэл байдлаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
	төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хэрэгжүүлнэ.					даргын Тамгийн газарт 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 01/2822 дугаартай бичгээр хүргүүлэв.	
3.7.	Нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй хүнсний худалдаа нийтийн хоол, үйлдвэрлэл үйлчилгээ, эрүүл мэндийн байгууллагад хяналт шалгалтыг хийх, холбогдох тогтоомжийн хэрэгжилтийг хангуулна.	10.0 УТ	Төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын тоо	356	200	Эрүүл мэндийн яамны Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын баталсан "Хяналт шалгалт хийх тухай" 10-00/05, 10-00/09, 10/00/14, 10-00/10 дугаартай удирдамжууд хүрээнд нийт 314 эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагад хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн байна. Шалгалтын явцад дараах ажлыг хийж гүйцэтгэсэн. Хяналт шалгалтын явцад 774 зөрчил илрүүлж, газар дээр нь 569 зөрчил буюу 56.9 %-ийг арилгуулж 1145 заалт бүхий 175 улсын (ахлах) байцаагчийн албан шаардлагаар хугацаатай үүрэг даалгавар хүргүүлэн, 38 аж ахуй нэгж, байгууллага, иргэнд 47850,0 төгрөгийн торгох шийтгэл оногдуулан бүрэн барагдуулсан. Мөн 7 аж ахуй нэгж байгууллагад 824040,0 төгрөгийн нөхөн төлбөр тогтоож 339742,0 мян төгрөгийг барагдуулсан. Хяналт шалгалтад хамрагдсан эмнэлгийн эмч, мэргэжилтэн нарт Эрүүл мэндийн тухай, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль болон түүнд нийцүүлэн гаргасан стандарт, Эрүүл мэндийн сайдын холбогдох тушаал, шийдвэр, журмын талаар танилцуулан, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулан, үүсч болох эрсдэлээс сэргийлэх, эрсдлийг бууруулах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.	100%
		10.0 УТ	Худалдаа, нийтийн хоол, үйлдвэрлэл үйлчилгээний газрын тоо	259	276	Эрүүл мэндийн яамны Салбарын хяналтын газрын даргын 10-00/13 дугаартай удирдамжийн хүрээнд худалдаа, нийтийн хоол, үйлдвэрлэл үйлчилгээний 276 объектод хяналт шалгалт хийхээс 268 (258+10) объектод хяналт шалгалт хийсэн. Шалгалтад хамрагдсан объектуудыг 12 хяналтын хуудсаар дүгнэхэд 16 (6.2%) нь "их", 113 (43.7%) нь "дунд", 129 (50%) нь "бага" эрсдэлтэй үнэлэгдэж, хууль, тогтоомжийн сахин мөрдөлтийн дундаж түвшин 70.8 хувь, эрсдэл үүсэх магадлалын дундаж хувь 28.5 хувьтай	90%

Д/д	Стратеги болон үндэслэл байдга бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
						тогтоогдсон бол 134 газарт гүйцэтгэлийн хяналт шалгалт хийсний дараа дунд эрсдэлтэй 45 (33.5%), бага эрсдэлтэй 89 (66.4%) объект үнэлэгдэж, үйл ажиллагааны хууль, тогтоомжийн сахин мөрдөлтийн дундаж түвшин 10 хувиар өссөн, эрсдэл үүсэх магадлалын дундаж хувь 11 хувиар буурч үнэлэгдсэн. Хяналт шалгалтын явцад 1240 зөрчил, дутагдлыг илгүүлэн, 634 буюу 60 хувийг газар дээр нь арилгуулж, 114 объектод 597 заалттай албан шаардлагаар хугацаатай үүрэг даалгавар өгч, 172 заалт бүхий 32 улсын (ахлах) байцаагчийн зөвлөмж хүргүүлэн, 14 хуулийн этгээд, иргэнд 23.600.000 төгрөгийн шийтгэл оногдуулан, илэрсэн зөрчлийг арилгуулах гүйцэтгэлийн хяналтаар биелэлт 83.7 хувьтай байна. Тагхимаар 7 дүүргийн нийт 175 хүнсний үйлдвэр, худалдаа, хоол үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгж, иргэдийг хамруулсан сургалт зохион байгуулж, 9 зөвлөмж, 12 гарын авлага, ном, сургалтын материал хүргүүлж, байгууллагын вэб сайтад 5 удаа мэдээ, мэдээлэл, зөвлөмж сэрэмжлүүлэг байршуулсан. Хяналт шалгалтаар их эрсдэлтэй объектын эзлэх хувийг 25 хувиар бууруулж, дунд болон бага эрсдэлтэй объектын эзлэх хувь 50 хувиар нэмэгдсэн байна.	8
		100.0 УТ	Ахуйн болон төв цэвэрлэх байгууламж, ус түгээх байрны тоо	374	170	Тайлант хугацаанд 170 ахуйн болон төв цэвэрлэх байгууламж, ус түгээх байранд хяналт шалгалт хийхээс 227 объектод хийсэн байна. Үүнд: 1. Эрүүл мэндийн яамны Салбарын хяналтын газрын 10-00,12 дугаартай удирдамжийн хүрээнд 219 ус түгээх байр, шугамын худаг, хэрэглэгчийн цэг зэрэг 219 объектоос 467 ундны усны дээж авч шинжлүүлэхэд сорилтын дүнгээр 58 дээж буюу 21.4% нь Хүрээлэн буй орчин, Эрүүлийг хамгаалах, Аюулгүй байдал, Ундны ус, Эрүүл ахуйн шаардлага MNS 0900:2018 стандартын шаардлага хангахгүй гарсан байна. Стандартын шаардлага хангаагүй 65 газрын шугам сүлжээ, нөөцийн савыг угааж,	100%

Д/д	Стратеги болон үндэслэл бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
						халдваргүйжүүлэн, давтан шинжилгээнд хамруулан, шинжилгээний дүнг үндэслэн, 134 дүгнэлт гаргаж, 1 аж ахуйн нэгжид 2.000.000 төгрөгийн шийтгэл ногдуулан, 1 аж ахуйн нэгжид албан даалгавараар хугацаатай үүрэг даалгавар хүргүүлж, хэрэгжилтийг тооцлоо. Шаардлага хангаагүй дээж эхний хагас жилд 17 хувь байсан бол 12 хувь болж буурсан байна. 2. Эрүүл мэндийн яамны Салбарын хяналтын газрын даргын 10-00/07 дугаартай удирдамжийн хүрээнд УСУГ-ын Төв, Нисэх, Харгиа, Биокмбинат, Чингэлтэй, Дамбадаржаа, Чандмань Налайх ОНӨААТҮГ, Жуулчин тэрэлж ресорт амралтын газар зэрэг 8 цэвэрлэх байгууламжийн цэвэрлэсэн бохир уснаас нийт 26 сорьц авч, хими, нян судлалын шинжилгээнд хамруулан, Хүээлэн буй орчин, Усны чанар, Хаягдал ус Ерөнхий шаардлага MNS 4943:2015, MNS 6561:2023 стандартад нийцэж буй эсэхэд үнэлэлт өглөө. Шинжилгээ сорилтын дүнгээр 22 буюу 84.6% нь стандартын шаардлага хангаж, 4 буюу 15.4 хувь нь стандартын шаардлагад нийцээгүй гарч, дүгнэлтийг холбогдох хуулийн этгээдэд хүргүүлээ. Засгийн газрын 53 дугаар тогтоолын дагуу Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжид бохир ус нийлүүлдэг үйлдвэрүүдийн хаягдал бохир усанд агуулагдах бодисын найрлагын хэмжээ, технологийн горимд хамтран хяналт шалгалтыг 71 үйлдвэрт хийж, бохир усны гаргалгаа шугамд бохирдол бууруулах тоног төхөөрөмж суурилуулах, урьдчилан цэвэрлэх байгууламж угсрах талаар 10 газарт албан шаардлагаар үүрэг өгч, биелэлтэд нь хяналт тавьж ажиглаж, 7 үйлдвэр урьдчилан цэвэрлэх байгууламж барьж эхлээд байна.	
3.8.	Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 19.1.3 дахь заалтад Эрүүл мэндийн байгууллага нь онц чухал	-	Дэмжлэг хяналтад хамрагдсан	6	22	Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын 2025 оны 02 сарын 14-ний өдрийн “Мэдээллийн аюулгүй байдалд хяналт үнэлгээ хийх тухай” А/34 дүгээр тушаалын дагуу 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдрөөс 03 дугаар сарын	100%

Д/д	Стратеги болон үндэслэл бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлийн хувь
1	2 мэдээллийн дэд бүтэцтэй байгууллага гэж заасан тул эрүүл мэндийн мэдээллийн аюулгүй байдал, мэдээллийн системийн өдөр тутмын үйл ажиллагааг явуулахад шаардлагатай сервер, тоног төхөөрөмжөөр ханган байнгын хяналт тавьж ажиллана.	3	4 байгууллагын тоо	5	6	7 17-ны өдрүүдэд харьяа эрүүл мэндийн байгууллагуудад мэдээллийн аюулгүй байдал, ил тод байдал, цахим программ ашиглалтын үйл ажиллагаанд хяналт, үнэлгээ хийж, тулгамдаж буй асуудлыг судлан, мэргэжил арга зүйгээр хангасан. Хяналт үнэлгээний дүнд үндэслэн харьяа 28 эрүүл мэндийн байгууллагад үйл ажиллагааг сайжруулах зөвлөмжийг 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 01.828 тоот албан бичгээр хүргүүлэн хяналт тавьж ажилласан. Мэдээллийн аюулгүй байдлыг хангах зорилгоор харьяа 10 эрүүл мэндийн байгууллага (БЗДЭМТ, ХУДЭМТ, ЧДЭМТ, СЭДЭМТ, БНДЭМТ, ХУДНЭ, БЗНЭ, СХНЭ, НТТТ, НХАГ, НӨАГ, Энэрэл эмнэлэг) сүлжээний галт хана (firewall) WatchGuard T45, T5, F80, M290 төхөөрөмжийг түрээсийн гэрээгээр худалдан авч, дотоод сүлжээнд гаднын халдлага, эрсдэлээс сэргийлэх, мэдээллийн аюулгүй байдлыг хангахаар ажиллаж байна. Дотоод сүлжээнд ашиглаж байгаа компьютер тоног төхөөрөмжүүдэд хор одоос сэргийлэх зорилгоор СБДНЭ, БЗДЭМТ, БЗДНЭ, ЧДЭМТ, СХДНЭ, НДЭМТ, БХДЭМТ, НХАГ-ууд Casperky болон eset security, endpoint security худалдан авч гаднын халдлага, хор одоос урьдчилан сэргийлэн ажиллаж байна.	8
		-	Тоног төхөөрөмжийн тоо /сүлжээний галт хан төхөөрөмж/	2	12		80%
3.9.	Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг харьяа эрүүл мэндийн байгууллагуудад үе шатай хийлгэн гарсан дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.	-	Эрсдэлийн үнэлгээ хийлгэсэн байгууллагын тоо	-	20	Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны А/98 дугаар тушаалд "Мэдээллийн аюулгүй байдлын аудит" 2 жил тутамд хийлгэх гэж заасны дагуу 2025 оны 2 дугаар сараас эхлэн 7 байгууллага буюу Баянзүрх дүүргийн нэгдсэн эмнэлэг, Нийслэлийн түргэн тусламжийн төв, Багануур дүүргийн эрүүл мэндийн төв, Нийслэлийн хүрээ амаржих газар, Нийслэлийн амгалан амаржих газар, Энэрэл эмнэлэг, Сонгинохайрхан нэгдсэн эмнэлэг эрх бүхий байгууллагаар мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг хийлгэж дүгнэлтийн дагуу зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж байна.	35%

Д/д	Стратеги болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
						Бусад эрүүл мэндийн байгууллага нь төсөв санхүүжилт хангалтгүй, шаардлагатай төсвийн зарцуулалтыг олгоогүй улмаас 2025 онд мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ, аудит хийлгэх боломжгүй байна. Байгууллагууд төлөвлөгөөний дагуу кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийлгэх асуудлыг 2026 оны төсвийн төлөвлөгөөнд тусган ажиллаж байна.	
3.10	Улс, Нийслэлийн төсөв болон бусад эх үүсвэрээр 2025 онд нийслэлд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, санхүүжилтийн үйл ажиллагааг Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон холбогдох журамд нийцүүлэн ил тод шуурхай, зохион байгуулж хугацаанд нь чанартай гүйцэтгэж, үнэн зөв бодитой тайлагнана.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	100	100	Нийслэлийн Засаг даргын 2024 оны 1, 2025 оны 2 захирамжаар эрх шилжин ирсэн нийт 20 төсөл, арга хэмжээ байна. 1. Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/1156 дугаар захирамжийн дагуу эрх шилжсэн нийт 8 төсөл, арга хэмжээний 42 багц ажлын худалдан авах ажиллагааг Нийслэлийн худалдан авах ажиллагааны газар зохион байгуулсан. Үүнээс: Бүрэн хэрэгжсэн 41 багц ажил, хэрэгжиж байгаа 1 багц ажил байна. 2. Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/107 дугаар захирамжийн дагуу эрх шилжсэн нийт 11 төсөл, арга хэмжээний 43 багц ажлын худалдан авах ажиллагааг Нийслэлийн худалдан авах ажиллагааны газар зохион байгуулсан. Үүнээс: Бүрэн хэрэгжсэн 34 багц ажил, хэрэгжиж байгаа 9 багц ажил байна. 3. Нийслэлийн төсвийн хөрөнгөөр Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/430 дугаар захирамжийн дагуу эрх шилжсэн "Чингэлтэй дүүргийн эрт илрүүлэг оношилгооны төвд шаардлагатай тоног төхөөрөмж төсөл, арга хэмжээний нийт 6 багц ажлын худалдан авах ажиллагааг Нийслэлийн худалдан авах ажиллагааны газар зохион байгуулсан. Үүнээс: Бүрэн хэрэгжсэн 5 багц ажил, хэрэгжиж байгаа 1 багц ажил байна.	100%
3.11	Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний ажилд захиалагчийн хяналт тавьж ажиллахдаа холбогдох хууль, журамд	-	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	100	100	Нийслэлийн төсвийн хөрөнгөөр Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/1156 дугаар захирамжийн дагуу 8 төсөл, арга хэмжээ, Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/107 дугаар захирамжийн дагуу 11 төсөл, арга хэмжээ, Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/430 дугаар захирамжийн дагуу 1	100%

Д/д	Стратеги болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
	нийцүүлэн, үнэн зөв, бодитой тайлагнаж, мэргэжлийн байгууллага хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулан, тулгамдсан асуудлыг тухай бүр шийдвэрлэж, хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлийн бүх үе шатанд тавих хяналтыг сайжруулж ажиллана.					төсөл, арга хэмжээ, нийт 20 төсөл, арга хэмжээний 91 багц ажлын худалдан авах ажиллагааг Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар зохион байгуулж, Нийслэлийн Эрүүл мэндийн газар захиалагчийн хяналтыг хийж, холбогдох хууль, журамд нийцүүлэн, үнэн зөв, бодитой тайлагнаж ажиллаж байна.	
3.12	Монгол Услын Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/250 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын дагуу Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (tender.gov.mn)- ээр худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг санхүүжилтийн эх үүсвэр батлагдснаас хойш ажлын 10 хоногт багтаан батлуулах, тайланг төсвийн жил дууссан даруйд системээр тайлагнана.	-	Цахим системд тайлагнасан төсөл арга хэмжээний тоо	-	Төсвийн жил дууссан даруйд зохион байгуул сан нийт төсөл, арга хэмжээг системд бүрэн тайлагн асан байна.	Монгол Улсын Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/250 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын дагуу Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (tender.gov.mn)-ээр худалдан авах ажиллагааны 2024 оны тайлан, 2025 оны төлөвлөгөөг хуулийн хугацаанд тайлагнасан. 2025 оны худалдан авах ажиллагааны тайланг тайлагнах хугацаа болоогүй байгаа бөгөөд дараа оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор хугацаанд нь тайлагнаж ажиллана.	100%

Д/д	Стратеги болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
3.13	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд газрын үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	100	100	Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дэргэдэх Ёс зүйн дэд хороо нь 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж батлан хэрэгжүүлж байна. 9 заалт бүхий төлөвлөгөөний хэрэгжилт 90 хувьтай байна.	90%
3.14	Төрийн албан хаагчид ёс зүйн асуудлаар зөвлөгөө, мэдээлэл өгөх, удирдамж, заавраар хангах, сургалт, нөлөөллийн үйл ажиллагаа явуулах боломж, нөхцөл бүхий орчныг бүрдүүлж, Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	-	100	Байгууллагын зүгээс 2025 оны 03 сарын 17-нд Монгол Улсын Төрийн албаны зөвлөлд хандаж тус газрын төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдыг төрийн албан хаагчийн ёс зүй, хариуцлага, албан ажлын зохион байгуулалт, харилцааны соёл захирах захирагдах ёс, албан хувцаслалтын талаарх сургалтад хамруулах хүсэлтийг хүргүүлсэн. Энэ хүрээнд ёс зүйн хорооны гишүүн АУ-ны доктор, дэд профессор, хууль зүйн ухааны магистр М.Цэрэнбат 94 албан хаагчдад 4 цагийн лекц, мөн "Сэтгэл ба эрхтэн" төвийн тэргүүн Р.Энхтүвшин байгууллагын болон хувь хүний хөгжил, сэтгэлийн эрхтэн сэдвээр "Стресс менежмент" ийн 4 цагийн лекц, илтгэлийг 54 албан хаагчдад зохион байгуулсан.	100%
3.15	Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг мөрдүүлэх, хэвшүүлэх, баримтлан ажиллахад чиглэсэн үйл ажиллагааг	-	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	-	2	Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийн хэрэглээ хэлэлцүүлэгт Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга оролцож салбарын санал бодлыг солилцож ажилласан. Ёс зүйн дэд хороо, Захиргаа, нэгдсэн удирдлагын хэлтэс хамтран "Ёс зүйн дэд хорооны дүрэм" шинэчлэн батлуулахаар боловсруулан Авлигатай тэмцэх газраас санал авч, Газрын даргын 2025 оны 04 дүгээр сарын 30-ний өдрийн А/98 дугаар тушаалаар батлуулсан.	100%

Д/д	Стратеги болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
	байгууллагын удирдлага манлайлан, Ёс зүйн дэд хорооны дэмжлэгтэйгээр тогтмол хэрэгжүүлнэ.					Авлигатай тэмцэх газар, Нийслэлийн прокурорын газартай хамтран тусгай зөвшөөрлийн хариуцсан албан хаагчид болон шинжээчээр ажиллаж буй 40 албан хаагч сургалтад хамруулсан. Ёс зүйн дэд хороо 2025 онд нийтдээ 11 гомдол хүлээж авч шидвэрлэн, үүнтэй холбоотой гаргасан алдаа дутагдлыг даван гаргуулахгүй байх үүднээс сургалтын удирдамж боловсруулан захиргаа, нэгдсэн удирдлагын хэлтэстэй хамтран нийт 3 албан хаагчдад нэг удаагийн танхимын сургалт орсон байна. Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 1 удаагийн сургалтад албан хаагчдыг хамруулсан.	
3.16	Ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлэхэд иргэний нийгэм, хувийн хэвшил, хэвлэл мэдээллийн байгууллагын оролцоог хангана.	-	Арга хэмжээний тоо	-	2	Ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлэхэд иргэний оролцоог хангах зорилгоор иргэдэд чиглэсэн постер мэдээллийг Ёс зүйн дэд хорооноос бэлтгэн НЭМГ-ын пэйж хуудсаар дамжуулан "Үйлчлүүлэгчийн ёс зүй", "Иргэний төрийн байгууллагаар үйлчилгээ авахад анхаарах зүйлс" зэрэг сэдвийн хүрээнд мэдээлэл тогтмол хүргэж ажилласан. Мөн нутгийн захиргааны "ERP" системд Төрийн албан хаагчийн ёс зүйтэй байх талаар уриалгад нэгдэн, дэмжиж ажилласан. Ёс зүйн дэд хороо нь 2025 онд үйл ажиллагаа явуулахдаа хэвлэл мэдээллийн 'time.mn', 'dodo.mn', 'Монголын үндэсний телевиз', "Улаанбаатар мэдээ" гэх мэт газруудтай хамтран төрийн албан хаагчийн ёс зүй, НЭМГ- ын харьяа эрүүл мэндийн 28 байгууллага, албан хаагчдын ёс зүйн талаарх мэдээллийг тогтмол хэвлэл мэдээллээр хүргүүлсэн.	100%
3.17	Авлигын эсрэг үйл ажиллагааны газрын төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг хангана.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	100	100	Байгууллагын Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг таван зорилго, 15 арга хэмжээтэй баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Харьяа эрүүл мэндийн байгууллагаас гаргасан 2 контент болон авилгатай тэмцэх газраас соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн контентуудыг байгууллагын болон харьяа 28 эрүүл мэндийн байгууллагын дотоод сүлжээ бусад хэлбэрээр сурталчилан ажилласан. Үүнд: албан	100%

Д/д	Стратеги болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
						ёсны цахим хуудсаар болон сайтаар давхардсан тоогоор 65449 хандалттай байна. Өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан харьяа байгууллагууд нөөц бололцоондоо тохируулан нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулан 1700 хүн оролцуулан зурагт хуудас 1459 тарааж ажилласан байна. НЭМГ болон харьяа эрүүл мэндийн байгууллагууд төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт эдийн засгийн ангилал, байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт эдгээр мэдээллийг сар бүр хуулийн хугацаанд шилэн дансанд байршуулж ажиллаж байна. Авлигыг мэдээлэх 110 тусгай дугаарыг тус газар болон харьяа эрүүл мэндийн байгууллагууд тухай бүр өөрсдийн дотоод сүлжээ, ERP системд байршуулж ажилласан. Тус газарт илэрсэн 1 зөрчил мэдээллийг 110 тусгай дугаарт мэдэгдэн хэрэг үүсгэдэн шалгагдаж байна. Авлигатай тэмцэх газартай хамтран 2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр НЭМГ-ын харьяа ӨЗМТ-ийн 132 дарга нарт Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулсан. Мөн Авлигатай тэмцэх газар, Эрүүл мэндийн чанарын холбоотой хамтран 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдөр Нийслэлийн харьяа эрүүл мэндийн байгууллагуудын 112 Чанарын менежер, эмч, эмнэлгийн мэргэжилтэнд сэрэмжүүлэг болгох үүднээс Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа сэдвээр уулзалт сургалт зохион байгууллаа. 2025 оны 12 дугаар сарын 02-ны өдөр Авлигатай тэмцэх газар, Нийслэлийн прокуратурын газартай хамтран тусгай зөвшөөрлийн хариуцсан албан хаагчид болон хяналтаар ажиллаж буй 40 албан хаагчдыг сургалтад хамруулсан. Уг хяналтаар ажиллаж буй албан хаагчдаас тухай бүр Ашиг	

Д/д	Стратеги болон үндэслэл бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
						сонирхлын зөрчилгүй тухай мэдэгдэл маягтыг авч ажиллаж байна. 2025 онд шинэчлэн батлуулсан байгууллагын дотоод журамд нууцын тухай зүйл заалтыг дэлгэрэнгүй тусгаж, ажилтан томилж ажиллуулж байна. Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж, хууль тогтоомжийн хэрэгжилтүүдийг хангуулж, хэрэг үүсгэн шалгагдаж буй хэргүүдийн нотлох баримтуудыг тухай бүр шаардлага хангуулан хүргүүлж ажилласан. Төлөвлөгөөний хэрэгжилт 100%-тай байна.	
3.18	Авлигатай үндэсний хэрэгжүүлэх хэмжээний төлөвлөгөө (2024-2030 он)-г хэрэгжүүлж, Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлнэ.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	100	100	2025 оны хагас болон бүтэн жилийн үйл ажиллагааны хэрэгжилтийн тайланг нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудын хэмжээнд нэгтгэн нотломжийн хамт НЗДТГ-т хугацаанд нь хүргүүлсэн. Хөтөлбөрийн хэрэгжилт 100%-тай байна.	100%
3.19	Харьяа эрүүл мэндийн байгууллагын удирдах ажилтныг хууль журмын дагуу томилж, хүний нөөцийн хөгжлийг хангаж ажиллана.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	-	100	Нийслэлийн харьяа Хүрээ амаржих газар болон Туул, Жаргалант тосгоны Эрүүл мэндийн төвийн даргын албан тушаалын сул орон тооны мэдээлэл, сонгон шалгаруулалтын захиалгыг батлагдсан албан тушаалын тодорхойлолт, тухайн албан тушаалын сул орон тоо гарсныг нотлох шийдвэрийн хамт 2025 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 01/386 дугаар албан бичгээр Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөлд хүргүүлсэн бөгөөд удирдах албан тушаалтны сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалт 2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр зохион байгуулагдаж, сонгон шалгаруулалтад тэнцсэн төсвийн шууд захирагч нарыг Төрийн албаны	100%

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэл байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
						зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөлийн тогтоолыг үндэслэн албан тушаалд томилсон. Хөдөлмөрийн тухай хуулийн 56 дугаар зүйлийг үндэслэн түр орлон гүйцэтгэгч, хавсран гүйцэтгэгчээр томилогдсон харьяа 9 эрүүл мэндийн байгууллагын удирдах ажилтны сул орон тооны захиалгыг холбогдох материалын хамт Нийслэл дэх салбар зөвлөлд 2025 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн албан бичгээр хүргүүлсэн.	
3.20	"Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III" хүрээнд албан хаагчдын монгол бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлж, байгууллагын албан хэрэг хөтлөлтийг хос бичгээр хөтөлнө.	-	Хос бичгээр хөтөлсөн албан бичгийн хувь	-	100	2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар тус газраас бусад төрийн байгууллага, аж ахуйн нэгж иргэнд 2829 албан бичиг явуулснаас төрийн байгууллагад хүргүүлсэн 1651 албан бичгийг Монгол бичгээр хөрвүүлэн хос бичгээр хөтөлсөн. Байгууллагын хэмжээнд 2025 онд гарсан 464 (А тушаал 331 Б тушаал 193) тушаалыг 100% хос бичгээр хөтөлсөн.	100%
		-	Монгол бичгийн сургалт ад хамрагдсан албан хаагчийн хувь	50	100	Нийслэлийн Эрүүл мэндийн газрын 97 албан хаагчаас төлөвлөгөөний дагуу 97 албан хаагчийг 100% Монгол бичгийн сургалтад хамруулсан. Мөн Улсын хэмжээнд зохион байгуулагдаж буй "Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл улсын үзлэг"-ийн үр дүнтэй холбогдуулан нийт албан хаагчдад албан хэрэг хөтлөлтийн стандартын талаар сургалт хийж тараах материалыг ахлах мэргэжилтнүүдэд өгч, дундын мэдээллийн санд байршуулсан.	100%
Зорилт 4. Дүрмээр хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд: Эрүүл мэндийн байгууллагуудын материаллаг бааз, барилга, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, автомашин ашиглалт, засвар үйлчилгээ нөхөн хангалтыг нэгтгэн зохион байгуулна. /НХТЖТ-2.11.1/							
4.1.	Жишиг өрхийн эрүүл мэндийн төвийн барилга угсралтын ажлыг үргэлжлүүлнэ. /Баянзүрх, Чингэлтэй, Сонгинохайрхан дүүрэг/	1,800.0 ГЗ /АХБ/	Барилгын угсралтын ажлын гүйцэтгэлийн хувь	20	50	Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк (АХБ)-ны хооронд байгуулсан гэрээний дагуу хэрэгжиж буй "Эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөр" төслийн хүрээнд салбар хоорондын ажлыг уялдуулан зохицуулах, төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэн ажиллаж байна. Барилгын явц 70 хувьтай байна.	100%

Д/д	Стратеги болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
						1. Чингэлтэй дүүргийн 19 дүгээр хорооны барилгын ажлыг 3.2 тэрбум төгрөгөөр гүйцэтгэхээр "Юузэт Эрдэнэ" ХХК гэрээ байгуулагдсан. Барилгын ажил суурь цутгалтын ажил, суурийн шороо дүүргэлтийн ажил тус тус бүрэн дууссан. Барилгын бетон дүүргэлтийн ажил гадна дотор талын ханын өрлөгийн ажил, дээврийн ажил, цонх суулгалтын ажил бүрэн хийгдсэн. Гадна фасадны хавтан суулгалтын рам төмөр угсралтын ажил болон цахилгаан, сантехникийн ажил үргэлжилж байна. Барилга угсралтын ажлын гүйцэтгэл 80 хувьтай байна. 2. Сонгинохайрхан дүүргийн 26 дугаар хорооны зураг төсөвт магадлан хийгдэж дууссан. Барилгын ажлын гүйцэтгэх байгууллагыг шалгаруулах тендерийг төсөл хэрэгжүүлэх байгууллага зарлаж, 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр тендерийн нээлт хийгдсэн. Тендер шалгаруулалтаар барилгын ажлыг 2.65 тэрбум төгрөгөөр гүйцэтгэхээр "Скудотаур" ХХК шалгарч гэрээ байгуулсан. Барилгын бетон дүүргэлтийн ажил гадна дотор талын ханын өрлөгийн ажил, дээврийн ажил, гадна тохижилтын ажил бүрэн хийгдсэн. Цахилгаан болон дулааны асуудал шийдэгдэж хангагдсан. Гадна фасадны хавтан суулгалтын рам төмөр угсралтын ажил болон дотор талын ханын шавардлагаа заслын ажил үргэлжилж байна. Барилга ажлын гүйцэтгэл 90 хувьтай байна. 3. Баянзүрх дүүргийн 17 дугаар хорооны гүйцэтгэгчээр "Далуу" ХХК шалгарсан, барилгын ажил эхэлсэн боловч барилгажих талбайн хөрснөөс ус гарч, барилгын батлагдсан зураг өөрчлөгдөж дахин магадлангаар баталгаажсан. Барилгын араг багана бетон дүүргэлтийн ажил, давхарын хавтангийн ажил бүрэн хийгдсэн бөгөөд улиралын чанартай барилга угсралтын ажил зогссон. Барилга угсралтын ажлын гүйцэтгэл 30 хувьтай байна.	
4.2.	Нийслэлийн Аддиктологийн төвийн	12,631. 6 HT		40	60	Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар Аддиктологийн төвийн хуучин барилгыг нурааж, шинээр барих ажлыг	100%

Д/д	Стратеги болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлийн хувь
1	2 барилгын үргэлжлүүлнэ.	3	4	5	6	7	8
	ажлыг		Барилгын угсралтын ажлын гүйцэтгэлийн хувь			2022-2026 онд нийт төсөвт өртөг нь 39.8 тэрбум төгрөгийг төсөвлөсөн. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтын дагуу Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/170 дугаар захирамжаар Аддиктологийн эмнэлгийн барилгын ажлыг эхлүүлэх эрхийг Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газарт шилжүүлсэн. Уг тендэрт "Бүрэн Одод" ХХК нь шалгарч 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр гэрээ байгуулж, хуучин барилгын ажлыг нурааж буулгалтын ажил хийгдсэн. Барилгын бетон дүүргэлтийн ажил, гадна, дотор талын өрлөгийн ажил, гадна фасадны дулаалгын ажил, дээврийн ажил, гадна зам талбайн тохижилтын ажил, цонх суулгалтын ажил, дулааны шугам сүлжээ, цэвэр бохир усны хоолойн холболт угсралтын ажил бүрэн дууссан. Цахилгаан эрчим хүчээр хангагдсан. Дотор талын заслын ажил үргэлжилж байна. Барилгыг 2026 оны 2 дугаар сард ашиглалтад бүрэн хүлээлгэж өгөх ба барилга угсралтын ажил 90 хувийн гүйцэтгэлтэй үргэлжилж байна.	
4.3.	Чингэлтэй дүүргийн жишиг нэгдсэн эмнэлгийн барилга угсралтын ажлыг эхлүүлнэ.	12,000 ГЗ /АХБ/	Барилгын угсралтын ажлын гүйцэтгэлийн хувь	-	10	Монгол Улсын Засгийн газар болон Азийн Хөгжлийн Банк хооронд байгуулсан 3843-MON, 3844-MON (COL) гэрээний дагуу "Эмзэг бүлгийн хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөр" төслийн хүрээнд Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр барихаар төлөвлөсөн Чингэлтэй жишиг нэгдсэн эмнэлгийн инженерийн шугам сүлжээний дэд бүтэц (цахилгаа, дулаан, цэвэр бохир ус, харилцаа холбоо) инженерийн шугам сүлжээний зураг төслийг "Ричвел интернейшнл" ХХК гүйцэтгэж байна. Дэд бүтэцтэй холбоотой асуудлыг шийдвэрлэвэл барилгын ажлыг эхлүүлэх боломжтой болно. Газар чөлөөлөлтийн ажил үргэлжилж байна. Барилгын зураг магадлал хийгдсэн бөгөөд дүгнэлт гараагүй байна.	-

Д/д	Стратеги болон үндэслэлж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
						Чингэлтэй дүүрэгт баригдах эмнэлэг нь АХБ-ны төслийн 2-3 дугаар үе шатанд хамрагдах бөгөөд МУЗГ-аар орж баталгаажсан. Олон улсын тендер зарлагдаана.	
4.4.	Хан-Уул дүүрэгт нэгдсэн эмнэлгийн барилгын ажлыг үргэлжлүүлнэ.	48,000.0 ГЗ /АХБ/	Барилгын угсралтын ажлын гүйцэтгэлийн хувь	20	50	Монгол Улсын Засгийн газар болон Азийн Хөгжлийн Банк хооронд байгуулсан 3843-MON, 3844-MON (COL) гэрээний дагуу "Эмзэг бүлгийн хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөр" төслийн хүрээнд Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр Хан-Уул дүүргийн жишиг Нэгдсэн эмнэлгийн барилга баригдаж байна. Барилгын ажлын гүйцэтгэгчээр хятадын төмөр замын 1 дүгээр компани шалгарч гэрээ байгуулсан. Барилгын суурийн ажил бүрэн хийгдэж, барилгын арагт бетон дүүргэлтийн ажил, гадна ханын өрлөгийн ажил, дээврийн ажил бүрэн дууссан. Цонхны рам суулгагдаж шил суулгалтын ажил үргэлжилж байна. Барилгын явц 40 хувьтай байна.	80%
4.5.	Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилгын ажлыг дуусгана.	8,960.2 УТ	Барилгын угсралтын ажлын гүйцэтгэлийн хувь	65	100	Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилгын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг Төрийн худалдан авах ажиллагааны газар зохион байгуулж, гүйцэтгэгчээр "Солармед монгол" ХХК шалгарч 19.3 тэрбум төгрөгөөр гэрээ байгуулсан. Барилга нь 2024 оны 12 дугаар сарын 30-нд ашиглалтанд орох байсан ч эмнэлгийн барилгын цахилгааны дэд өртөөг байгуулахад шаардлагатай газрын болон инженерийн шугам сүлжээний ажилтай холбоотойгоор 2025 оны 10 дугаар сард ашиглалтад оруулахаар болж Эрүүл мэндийн яам гэрээг сунгасан байна. Барилгын төмөр бетон арагт бүтээцийн ажил болон гадна ханын өрлөгийн ажил бүрэн хийгдсэн. Гадна фасад дулаалга, цонх суулгалтын ажил үргэлжилж байна. Барилгын явц 80 хувьтай байна.	80%
4.6.	Чингэлтэй дүүргийн эрүүл мэндийн төвийн "Эрт илрүүлэг, оношилгооны төв"-ийн барилгын ажлыг дуусгана.	980.1 УТ	Барилгын угсралтын ажлын гүйцэтгэлийн хувь	85	100	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээ Эрт илрүүлэг, оношилгооны төвийн барилгын ажлыг эхлүүлэхэд 2022-2024 онд нийт төсөв 5.5 тэрбум төгрөг, Эрт илрүүлэг, оношилгооны төвийн барилгын тендерийг Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар	100%

Д/д	Стратеги болон үндэслэл Байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
						зохион байгуулж, гүйцэтгэгчээр "Монхауз" ХХК шалгарч, 2022 оны 10 дугаар сарын 12-ны өдөр гэрээ байгуулсан. Барилга угсралтын ажил бүрэн дуусч барилга хүлээн авч ашиглалтад оруулах улсын комисс ажиллаж хугацаатай үүрэг даалгавар өгсөн байна. Барилга угсралтын ажлын гүйцэтгэл 100 хувь хэрэгжсэн. Улсын комисс бүрэн ажиллаж дууссаны дараа эмнэлгийн үйл ажиллагааг эхлүүлнэ.	
4.7.	Гачуурт тосгоны эрүүл мэндийн төвийн барилга угсралтын ажлыг дуусгана.	500.0 УТ	Барилгын угсралтын ажлын гүйцэтгэлийн хувь	90	100	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Гачуурт тосгон Эрүүл мэндийн барилгын ажлыг 2022-2024 онд нийт төсөвт өртөг нь 3.2 тэрбум баталсан. Барилгын ажлыг 2.9 тэрбум төгрөгөөр гүйцэтгэхээр "Пи Эм" ХХК шалгарч, гүйцэтгэсэн. Барилгын ажлыг бүрэн дуусгаж 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр улсын комисс хүлээн авч 100 хувь ашиглалтад орсон.	100%
4.8.	Нийслэлийн хүүхдийн сэргээн засах "Эрүүл үрс" төвийн барилгын ажлыг үргэлжлүүлнэ.	8,118.7 УТ	Барилгын угсралтын ажлын гүйцэтгэлийн хувь	20	70	Улсын төсвийн хөрөнгөөр Нийслэлийн хүүхдийн сэргээн засах "Эрүүл үрс" төвийн барилгын ажилд 2024-2026 онд шаардлагатай нийт төсөв болох 14.9 тэрбум төгрөгийг төсөвлөсөн. Барилгын ажлыг 14.6 тэрбум төгрөгөөр гүйцэтгэхээр "Элбэгүн" ХХК шалгарч гэрээ байгуулсан. Барилгын бетон дүүргэлтийн ажил, гадна, дотор талын өрлөгийн ажил, гадна фасадны дулаалгын ажил, дээврийн ажил, гадна зам талбайн тохижилтын ажил, цонх суулгалтын ажил, дулааны шугам сүлжээ, цэвэр бохир усны хоолойн холболт угсралтын ажил бүрэн дууссан. Цахилгаан эрчим хүчээр хангагдсан. Дотор талын заслын ажил үргэлжилж байна. Барилга угсралтын ажлын гүйцэтгэл 80 хувьтай байна.	100%
4.9.	Эрүүл мэндийн байгууллагын барилгын их засварын ажлыг хийнэ. (СХДЭМТ)	4,429.5 НТ	Барилгын угсралтын ажлын гүйцэтгэлийн хувь	-	100	Нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих "Дүүргийн эрүүл мэндийн төвийн барилгын их засвар-2 (Сонгинохайрхан дүүрэг, 13 дугаар хороо)" төсөл, арга хэмжээний ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг шалгаруулах тендерийг Сонгинохайрхан дүүргийн Худалдан авах ажиллагааны алба зохион байгуулж, Засаг даргын тамгын газар захиалагчийн хяналтыг тавин ажиллаж байна. Барилгын	-

Д/д	Стратеги болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
						ажлыг 4.4 тэрбум төгрөгөөр гүйцэтгэхээр "Бүрэн Одод" ХХК шалгарч гэрээ байгуулсан. Барилгын их засварын ажлын явц 40 хувьтай. Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн "Төсвийн хэмнэлтэд тооцох тухай" 02 дугаар тогтоол, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1.1, 1.2, 1.3 дэх заалтын дагуу 5 дугаар сарын 31-ний өдрөөс хойш гэрээ байгуулсан тул санхүүжилтгүй болж барилгын ажил түр хугацаагаар зогссон байна.	
4.10	Харьяа эрүүл мэндийн байгууллагуудад шаардлагатай автомашины хангалтыг нэмэгдүүлнэ.	1,580.0 НТ	Нийлүүлэх зориулалтын автомашины тоо	6	10	Нийслэлийн төсвийн хөрөнгөөр Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/107 дугаар захирамжаар эрх шилжсэн "Түргэн тусламжийн бүрэн тоноглогдсон автомашин (Улаанбаатар хот)" төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг Нийслэлийн худалдан авах ажиллагааны газар зохион байгуулж, уг ажлыг 1,580.0 сая төгрөгөөр нийлүүлэхээр "Монгол хьондай автоматив" ХХК гүйцэтгэхээр шалгарч гэрээ байгуулсан. Бараа нийлүүлэлтийн хугацаа болоогүй бөгөөд гэрээний дагуу 10 ширхэг бүрэн тоноглогдсон түргэн тусламжийн автомашин 12 сард нийлүүлэгдэхээр хүлээгдэж байна.	100%
4.11	Харьяа эрүүл мэндийн байгууллагуудын шинээр ашиглалтад орсон барилгын тоног төхөөрөмжийг нийлүүлнэ.	5,000.0 НТ	Ахмад настан, хүүхдийн эмнэлгийн тоног төхөөрөмжийн тоо /Баянзүрх дүүрэг/	-	107	Нийслэлийн төсвийн хөрөнгөөр Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/1156 дугаар захирамжийн дагуу эрх шилжсэн Баянзүрх дүүргийн "Ахмад настан, хүүхдийн эмнэлгийн тоног төхөөрөмж" төсөл, арга хэмжээний нийт 9 багц ажлын худалдан авах ажиллагааг Нийслэлийн худалдан авах ажиллагааны газар зохион байгуулж 9 багц ажил бүрэн хэрэгжсэн. Тус төсөл, арга хэмжээний багц тус бүрийн гэрээний дагуу гүйцэтгэлээр нийт 4.5 тэрбум төгрөгөөр 5 ширхэг суурин эхо аппарат, 5 ширхэг зөөврийн эхо аппарат, 3 ширхэг зүрхний эхо аппарат, 1 ширхэг суурин рентген аппарат, 2 ширхэг зөөврийн рентген аппарат, 10 нэр төрлийн 33 ширхэг лабораторийн тоног төхөөрөмж, 2 ширхэг	100%

Д/д	Стратеги болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
						ходоодны дуран, 1 ширхэг уушигны дуран, 32 нэр төрлийн 98 ширхэг амбулаторийн үзлэг оношилгооны тоног төхөөрөмжөөр хангасан. Мөн 21 нэр төрлийн 435 ширхэг багаж хэрэгсэл, 15 нэр төрлийн 27 ширхэг гал тогооны тоног төхөөрөмж, 21 нэр төрлийн 470 ширхэг тавилга, эд хогшилоор бүрэн хангасан. Нийт 47 нэр төрлийн 150 ширхэг эмнэлгийн тоног, төхөөрөмж нийлүүлэгдсэн.	
		6,098.4 0 НТ	Хүрээ амаржих газарт нийлүүлэх тоног төхөөрөмжийн тоо	-	180	Нийслэлийн төсвийн хөрөнгөөр Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/1156 дугаар захирамжийн дагуу эрх шилжсэн "Хүрээ амаржих газрын Эмнэлгийн тоног төхөөрөмж" төсөл, арга хэмжээний нийт 15 багц ажлын худалдан авах ажиллагааг Нийслэлийн худалдан авах ажиллагааны газар зохион байгуулж 15 багц ажил бүрэн хэрэгжсэн. Тус төсөл, арга хэмжээний багц тус бүрийн гэрээний дагуу гүйцэтгэлээр нийт 5.2 тэрбум төгрөгөөр 3 ширхэг суурин эхо аппарат, 18 нэр төрлийн 150 ширхэг эмнэлгийн тоног төхөөрөмж, 28 нэр төрлийн 516 ширхэг багаж, техник хэрэгсэл, 14 нэр төрлийн 16 ширхэг ариутгал халдваргүйтгэлийн тоног төхөөрөмж, 5 нэр төрлийн 7 ширхэг угаалгын хэсгийн тоног төхөөрөмж, 42 нэр төрлийн 57 ширхэг лабораторийн тоног төхөөрөмж, 21 нэр төрлийн 311 ширхэг мэдээлэл технологийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлээр хангасан. Мөн 24 нэр төрлийн 744 ширхэг эд хогшил, 9 нэр төрлийн 499 ширхэг эмнэлгийн хаягжилт, 2 нэр төрлийн 227 ширхэг хөшиг, 26 нэр төрлийн 1058 ширхэг тавилга, эд хогшлоор бүрэн хангасан. Нийт 103 нэр төрлийн 742 ширхэг эмнэлгийн тоног төхөөрөмж, багаж техник хэрэгсэл нийлүүлэгдсэн.	100%
		1,455.7 0 НТ	Нийгмийн эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмжийн	-	54	Нийслэлийн төсвийн хөрөнгөөр Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/1156 дугаар захирамжийн дагуу эрх шилжсэн "Баянзүрх дүүргийн Нийгмийн эрүүл мэндийн тоног төхөөрөмж" төсөл, арга хэмжээний нийт 6 багц ажлын	100%

Д/д	Стратеги болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
			тоо /Баянзүрх дүүрэг/			худалдан авах ажиллагааг Нийслэлийн худалдан авах ажиллагааны газар зохион байгуулсан. Үүнээс: Бүрэн хэрэгжсэн 5 багц ажил, хэрэгжиж байгаа 1 багц ажил байна. Тус төсөл, арга хэмжээний багц тус бүрийн гэрээний дагуу гүйцэтгэлээр нийт 1.4 тэрбум төгрөгөөр 1 ширхэг ходоодны дурангийн иж бүрдэл, 1 ширхэг тархины суурин эхо аппарат, 1 ширхэг суурин рентген аппарат, 1 ширхэг зөөврийн эхо аппарат, 5 нэр төрлийн 16 ширхэг эмнэлгийн тоног төхөөрөмж, 17 нэр төрлийн 61 ширхэг эмнэлгийн багаж техник хэрэгсэлээр хангасан. Мөн 13 нэр төрлийн 148 ширхэг тавилга, эд хогшилоор бүрэн хангасан. 7 нэр төрлийн 15 ширхэг лабораторийн тоног төхөөрөмжөөр хангагдана. Нийт 26 нэр төрлийн 81 ширхэг эмнэлгийн тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн.	
4.12.	Харьяа эрүүл мэндийн байгууллагуудыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана.	2,238.8 НТ	Нийлүүлэх тоног төхөөрөмжийн тоо	-	28	Нийслэлийн төсвийн хөрөнгөөр Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/430 дугаар захирамжийн дагуу эрх шилжсэн “Чингэлтэй дүүргийн эрт илрүүлэг оношилгооны төвд шаардлагатай тоног төхөөрөмж” төсөл, арга хэмжээний нийт 6 багц ажлын худалдан авах ажиллагааг Нийслэлийн худалдан авах ажиллагааны газар зохион байгуулсан. Үүнээс: Бүрэн хэрэгжсэн 5 багц ажил, хэрэгжиж байгаа 1 багц ажил байна. Тус төсөл, арга хэмжээний багц тус бүрийн гэрээний дагуу гүйцэтгэлээр нийт 2.1 тэрбум төгрөгөөр Чингэлтэй нэгдсэн эмнэлэгт 4 нэр төрлийн 4 ширхэг дүрс оношилгооны эхо аппарат, 1 ширхэг булчингийн цахилгаан бичлэгийн аппарат, 2 нэр төрлийн 2 ширхэг лабораторийн тоног төхөөрөмж, 5 нэр төрлийн 5 ширхэг ариутгал халдваргүйтгэлийн тоног төхөөрөмж, 4 нэр төрлийн 5 ширхэг угаалгын тоног төхөөрөмж, 13 нэр төрлийн 119 ширхэг мэдээлэл технологийн тоног төхөөрөмж, багаж, техник хэрэгсэлээр бүрэн хангагдсан. 3 нэр төрлийн 6 ширхэг амбулаторийн үзлэг, эмчилгээ оношилгооны тоног	96%

Д/д	Стратеги болон үндэслэл байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
						төхөөрөмжөөр хангагдана. Нийт 32 нэр төрлийн 148 тоног төхөөрөмжөөр хангахаас 142 ширхэг тоног төхөөрөмж, багаж техник хэрэгсэл нийлүүлэгдсэн.	
		9,993.0 НТ	Нийлүүлэх тоног төхөөрөмжийн тоо	-	421	Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/107 дугаар захирамжийн дагуу эрх шилжсэн нийт 10 төсөл, арга хэмжээний 43 багц ажлын худалдан авах ажиллагааг Нийслэлийн худалдан авах ажиллагааны газар зохион байгуулсан. Үүнээс: Бүрэн хэрэгжсэн 34 багц ажил, хэрэгжиж байгаа 9 багц ажил байна.	80%
4.13	Хүүхдийн сэргээн засах Бяцхан тэмүүлэл төвийн сувиллын барилгын зураг төсөв боловсруулна.	200.0 НТ	Зураг төсөв боловсруулах ажлын үйл явц хувиар	-	100	Нийслэлийн 2025 оны төсвийн тодотголын саналд Хүүхдийн сэргээн засах төвийн барилгын зураг, төсвийн ажлын саналыг 2025 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 01/249 дүгээр албан бичгээр Нийслэлийн Засаг даргын тамгын газарт хүргүүлсэн. Нийслэлийн төсөвт зураг төсвийн төсөв байхгүй шалтгаанаар шийдвэрлэгдээгүй байна.	-
Зорилт 5. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилтын хүрээнд: Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд төр хувийн хэвшлийг түншлэлийг эрчимжүүлж, төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээг цахимжуулах ажлыг сайжруулна.							
5.1	Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн нийслэлийн комиссын үйл ажиллагааг (тусгай зөвшөөрлийг шинээр олгох, үйл ажиллагааны чиглэл нэмэх, хүчингүй түүтгэлзүүлэх, зохион байгуулж, мэдээллийг цахимаар ил тод нээлттэй байршуулан авлига үүсэх эрсдэлээс сэргийлж ажиллана.	-	Тусгай зөвшөөрлийн комиссын хурал, тоо	11	11	2025 онд тусгай зөвшөөрлийн комисс 3 удаа хуралдсан ба ЭМС-ын сайдын 2025 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн "Тушаал хүчингүй болгох тухай" А/40 дүгээр тушаал гарснаар журам хүчингүй болж тусгай зөвшөөрлийн комисс татан буугдаж, тусгай зөвшөөрөлтэй холбоотой хурлыг НЭМГ-ын даргын Зөвлөлийн хуралд танилцуулж, шийдвэр гаргуулан ажилласан. Нийт 21 удаагийн Зөвлөлийн хурлыг зохион байгуулсан байна. 2025 оны 12 сарын 01-ний өдрийн байдлаар эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн хүсэлт ирүүлсэн байгууллагаас шаардлага хангасан 153 эмнэлэг, 121 Эмийн сан, 3 АШМУХУ-д тусгай зөвшөөрлийг олгож, 52 эмнэлэгт чиглэл нэмж, 8 эмнэлэгийн чиглэлийг хасаж, 1 эмнэлэг болон 8 эмийн сан, АШМУХУ-1 тусгай зөвшөөрлийг сэргээж, 3 эмнэлэг, 21 эмийн сан, 1 АШМУХУ-ийн тусгай зөвшөөрлийг түүдгэлзүүлж, 1 эмнэлэг, 35 эмийн сангийн тусгай	100%

Д/д	Стратеги болон үндэслэл бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
						зөвшөөрлийг хүчингүй болгоод байна. 159 эрүүл мэндийн байгууллагын тусгай зөвшөөрлийн гэрчилгээг шинээр олгож uhealth программд бүртгэсэн. Тусгай зөвшөөрөл сунгуулах хүсэлтийн дагуу ажлын байранд дүгнэлт гаргах ажлын хэсгийн багийг НЭМГ-ын даргын тушаалаар томилж нийт 702 (эмийн сан 436, эмнэлэг 266) хуулийн этгээдийн зөвшөөрлийг сунгаж, ажлын байр шилжин байршсан 212 (эмийн сан 145, эмнэлэг 67), эмийн сангийн эрхлэгч солих 227 хүсэлтийг бүрэн шийдвэрлэж, нийт 1141 хуулийн этгээдэд хууль, тогтоомж, стандартын хэрэгжилтийг хангуулан ажилласан. Бичиг баримтын шаардлага хангаагүй хүсэлт ирүүлсэн хуулийн этгээдийн хүсэлтийг тухай бүр тайлбар мэдээллийг цахим системд оруулан буцаасан. Шинээр тусгай зөвшөөрөл хүссэн 277, тусгай зөвшөөрлийн сунгалт хийлэх - 702, ажлын байрны дүгнэлт гаргах болон эзэмшигч солих 212, нийт 1191 хуулийн этгээдэд хууль, тогтоомж, стандартын хэрэгжилтийг хангуулан ажилласан.	
			Орон тооны бус шинжээчийг чадавхжуулахад зориулсан байгуулсан сургалтын тоо	2	2	ЭМС-ын сайдын 2025 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн "Тушаал хүчингүй болгох тухай" А/40 дүгээр тушаал гарч ЭМС-ын "Журам батлах тухай" 2023 оны А/100, А/383, А/402 тушаал хүчингүй болсноор тусгай зөвшөөрөл шинээр олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох болон ажлын байр шилжин байрших хүсэлтийн дагуу хөндлөнгийн шинжээчийг томилох, төслийн үнэлгээ хийх, ажлын байрны дүгнэлт гаргахад цаашид орон тооны бус шинжээч ажиллахгүй болсон тул сургалт зохион байгуулахгүй болсон.	-
			Ил тод нээлттэй байршуулсан мэдээллийн тоо	8	11	Шинээр эрүүл мэндийн чиглэлээр тусгай зөвшөөрөл олгосон 277, үйл ажиллагааны чиглэл нэмсэн 18 хуулийн этгээдийн мэдээллийг цахим бүртгэлд оруулж, байгууллагын цахим хуудсанд байршуулсан.	100%
5.2	Иргэдээс өргөдөл, шийдвэрлэхэд хууль, зүйн	-	Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн	12 хоног	10 хоног	Нийслэлийн Эрүүл мэндийн газрын өргөдөл гомдол шийдвэрлэлтийн 2025 оны төлөвлөгөө батлуулан ажиллаа.	50%

Д/д	Стратеги болон үндэслэл байдлаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлийн хувь
1	2 Үндэслэлтэй нэг мөр эцэслэн шийдвэрлэх, хариуг албан ёсоор өгч хэвших, өргөдөл, гомдлын хугацаа, зөрчлийн үзүүлэлтийг бууруулах, шийдвэрлэлтийг сайжруулна.	3	4 дундаж хоног	5	6	7 Тус газарт хандсан 1423 өргөдөл, гомдол, хүсэлтээс 1372 гомдол, хүсэлтийг бүрэн шийдвэрлэж, судлаж шийдвэрлэх шатанд 51 гомдол, хүсэлт байна. шийдвэрлэлт 96.5 хувьтай байна. Иргэдийн өргөдөл гомдлыг шийдвэрлэхдээ 962 гомдлыг иргэний талд, 410 өргөдөлд боломжгүй тухай хариу өгсөн бөгөөд албан бичгээр 370, утсаар 788, 102 иргэнд мессеж буюу цахим харилцаагаар хариуг хүргүүлж 112 иргэнтэй биечлэн уулзаж шийдвэрлэсэн байна. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн хоног 2024 оны мөн үетэй харьцуулахад дундаж хугацаа 12 хоног 10 цаг 46 минут байсан бол 2025 оны 11 дүгээр сарын 27-ны байдлаар 11 хоног 12 цаг 13 минут болж буурсан үзүүлэлттэй байна. Нийт зөрчил давхардсан тоогоор 139 байгаа бөгөөд өнгөрсөн онд 508 зөрчилтэй байсан бөгөөд мөн үеэс 369 зөрчлөөр буурсан үзүүлэлттэй байна.	8
			Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн хувь	96	97	1. Явцын тэмдэглэл хөтлөөгүй-64 2. Өдөрт нь багтаан хүлээн аваагүй-29 3. Өдөрт нь багтаан шилжүүлээгүй-45 4. Буцаалтыг 3 хоногт хийгээгүй-1 Байгууллагын дотоод сүлжээнд зөрчил гаргасан мэргэжилтний нэрсийг зарлаж хэлтсийн дарга нарт сануулж, мэргэжилтэн тус бүрээс тайлбар авч Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвд Өргөдөл гомдлын 7 хоногийн тайлангийн хамт хүргүүлэн ажиллаж байна. Өргөдөл гомдлын хандалтаас үзэхэд лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллага, ӨЗМТ болон эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаа, тамхины тусгай зөвшөөрлийн ажлын байрны дүгнэлт гаргуулах, орон сууцны 1 дүгээр давхарт байрлах үйлчилгээний газрууд, хоолны газар, баар рестораны үйлчилгээ, эрүүл ахуйн халдвар хамгааллын хяналт, нийтийн эзэмшлийн гудамж, ил задгай худалдаа, үйлчилгээ, хүнсний чанар, аюулгүй байдлын хяналт, эрүүл мэндийн байгууллагын хүний нөөц, яаралтай тусламж, үйлчилгээ, хувийн хэвшлийн эрүүл	

Д/д	Стратеги болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
5.3	ISO-9001 Чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх ажлыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа, удирдлагын газартай хамтарч эхлүүлнэ.	-	ISO-9001 Чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх бэлтгэл ажлын хувь	-	100	мэндийн байгууллагын тусламж үйлчилгээ, эрүүл мэндийн салбарын цалин, хөлс, төрийн албан хаагчийн ёс зүй, хог хаягдал шатаах, орчны зөгүй үнэр, агаарын бохирдолтой холбоотой гомдол нийт гомдлын 88.6 хувийг эзэлж байна.	
5.4	Өрхийн эрүүл мэндийн төвтэй байгуулсан гурвалсан гэрээний хэрэгжилтэд хяналт тавина.	-	Гэрээ байгуулсан өрхийн эрүүл мэндийн төвийн тоо	149	151	ISO-9001 Чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх ажлын хэсгийг шинэчлэн байгуулж, стандартыг нэвтрүүлэх, календарчилсан төлөвлөгөөг зөвлөх багтай хамтран гаргаж, хэрэгжилтийг ханган ажиллаа. ISO-9001:2025 Чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлж, 2025 оны 08 сарын 29-ний өдөр №20229735 дугаартай стандартын гэрчилгээг авсан.	100%
						Нийслэлийн Засаг даргын 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн "Гүйцэтгэлийн гэрээний биелэлтийн дүнг батлах тухай" А/145 дугаар захирамжийн дагуу "Бүрэн хангалттай", "Хангалттай" үнэлгээтэй 151 Өрхийн эрүүл мэндийн төвтэй 2025 оны гүйцэтгэлийн гэрээг тухайн дүүргийн Засаг даргын тамгын газар болон дүүргийн Эрүүл мэндийн төвүүд гэрээ байгуулсан. Нийслэлийн Засаг даргын 2025 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн "Гүйцэтгэлийн гэрээний биелэлтийн дүнг батлах тухай" А/1077 дугаар захирамжаар 151 өрхийн эрүүл мэндийн төвийн 2025 оны хагас жилийн гэрээний биелэлтийн дүнг баталсан. Эрүүл мэндийн сайдын 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн "Өрхийн эрүүл мэндийн төвтэй гэрээ байгуулах, хэрэгжилтийг дүгнэх, хяналт тавих, гэрээг сунгах, дуусгавар болгох журмыг батлах тухай" А/122 дугаар тушаалын дагуу өрхийн эрүүл мэндийн төвийн гэрээний хэрэгжилтийг 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор үнэлж, үнэлгээг ирүүлж хамтран ажиллах тухай албан бичгийг Дүүргийн Засаг даргын тамгийн газарт 2025.11.27-ны өдрийн 01/2831 дугаар албан бичгээр, мөн 8 дүүргийн Эрүүл мэндийн төвд 2025.11.27-ны өдрийн 01/2832 дугаар албан бичгээр тус тус хүргүүлсэн.	100%

Д/д	Стратеги болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
5.5	Барилга байгууламж барих зураг төсөл зохиох, ашиглалтад хүлээн авахад эрүүл ахуйн урьдчилсан хяналт хийж дүгнэлт гаргана.	-	Хамрагдсан объектын тоо	458	Хүсэлтээр	Эрүүл мэндийн яамны Салбарын хяналтын газрын даргын баталсан 10-00/01 дугаартай удирдамжийн хүрээнд барилга байгууламжийн зураг төсөлд эрүүл ахуйн хяналт хийлгүүлэх тухай 543 албан хүсэлтийг хүлээн авч, барилгын зураг төсөлд хяналт хийж, улсын (ахлах) байцаагчийн 471 дүгнэлт гарган, зураг төслийг баталгаажуулсан ба холбогдох норм дүрэм зөрчсөн, бичиг баримтын бүрдэл дутуу 72 зураг төслийг албан бичгээр буцаасан байна.	100%
5.6	Хуулийн хүрээнд согтууруулах ундаа худалдаалах түүгээр үйлчлэх зөвшөөрөл шинээр авах, зөвшөөрлийн хугацаа сунгуулах болон тамхи, тамхин бүтээгдэхүүн худалдах тусгай зөвшөөрөл шинээр авах, тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулахад аж ахуйн нэгжийн хүсэлтээр ажлын байранд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж, дүгнэлт гаргана.	-	Зөрчлийг арилгуулсан шийдвэрлэлтийн хувь	96	96.5	Барилга байгууламжийн зураг төсөлд эрүүл ахуйн хяналт хийхэд Эрүүл ахуйн тухай хуулийн холбогдох заалтыг зөрчсөн 17 аж ахуйн нэгжид 46.000.000 төгрөгийн шийтгэл ногдуулан бүрэн 100% барагдуулсан.	100%
			Тамхи, тамхин бүтээгдэхүүн худалдах ажлын байранд олгосон дүгнэлтийн тоо	96	Хүсэлтээр	Эрүүл мэндийн яамны Салбарын хяналтын газрын даргын баталсан 10-00/03 дугаартай удирдамжийн хүрээнд тамхи, тамхин бүтээгдэхүүн худалдаалах ажлын байрны дүгнэлт гаргуулахаар хүсэлт ирүүлсэн 741 аж ахуйн нэгжид төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж, №10.13.2 кодтой Тамхи, тамхин бүтээгдэхүүн худалдах ажлын байрны эрүүл ахуй, үйл ажиллагааг шалгах хяналтын хуудсаар эрсдэлийг үнэлж, бага эрсдэлтэй үнэлэгдсэн 643 объектод улсын байцаагчийн дүгнэлт гаргасан. Хяналтаар дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 44 аж ахуйн нэгжийн хүсэлтийг буцааж, холбогдох хууль тогтоомжийн нөхцөл, шаардлага хангаагүй, баримт бичгийн бүрдэл дутуу 54 объектод дүгнэлт гаргахаас татгалзсан хариу хүргүүлсэн.	100%
			Согтууруулах ундаа худалдаалах түүгээр үйлчлэх ажлын байранд олгосон дүгнэлтийн тоо	1172	Хүсэлтээр	Эрүүл мэндийн яамны Салбарын хяналтын газрын дарга, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Салбарын хяналтын дарга нарын баталсан 08-00-02/02 удирдамжийн хүрээнд согтууруулах ундаа худалдаалах, түүгээр үйлчлэх ажлын байрны дүгнэлт гаргуулахаар хүсэлт ирүүлсэн 1586 аж ахуйн үйл ажиллагаанд хяналтын хуудсаар эрсдэлийг үнэлж, хүнсний худалдааны 682, хоол үйлдвэрлэлийн 466, нийт 1148 үйлчилгээний ажлын байранд улсын (ахлах) байцаагчийн дүгнэлт гаргасан.	100%

Д/д	Стратеги болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	8
						Хяналтаар их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 356 аж ахуйн нэгжийн хүсэлтийг буцааж, холбогдох хууль тогтоомжийн нөхцөл, шаардлага хангаагүй, баримт бичгийн бүрдэл дутуу 82 объектод дүгнэлт гаргахаас таггалзсан хариу хүргүүлсэн.	
	Хэрэгжилтийн дундаж хувь						92.2